



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ  
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН  
ТАНХИМ



# ЦАР ТАХЛЫН ДАРААХ БИЗНЕСИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

## ТАЙЛАН



## АГУУЛГА

<b>ӨМНӨХ ҮГ</b> .....	<b>1</b>
<b>I. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ</b> .....	<b>2</b>
I-1. Бодит сектор.....	2
<i>Бодит секторын онцлох дүгнэлт</i> .....	8
I-2. Мөнгө, санхүүгийн сектор .....	9
<i>Мөнгө, санхүүгийн секторын онцлох дүгнэлт</i> .....	14
I-3. Засгийн газрын сектор .....	15
<i>Засгийн газрын секторын онцлох дүгнэлт</i> .....	18
I-4. Гадаад сектор.....	19
<i>Гадаад секторын онцлох дүгнэлт</i> .....	23
I-5. Өрхийн үзүүлэлтүүд.....	24
<i>Өрхийн үзүүлэлтийн онцлох дүгнэлт</i> .....	25
I-6. Эдийн засгийн цаашдын төлөв.....	26
<b>II. ЦАР ТАХЛЫН ДАРААХ БИЗНЕСИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА</b> .....	<b>27</b>
<i>Ерөнхий үр дүн</i> .....	27
II-1. Бизнесийн нөхцөл байдал .....	29
<i>Бизнесийн үйл ажиллагааны нөхцөл байдал</i> .....	29
<i>Бизнес дэх нөлөө</i> .....	32
<i>Нэгдүгээр хэсгийн дүгнэлт</i> .....	33
II-2. Бизнес дэх үнийн өсөлт, санхүүгийн нөлөө .....	34
<i>Бизнес дэх үнийн өсөлтийн нөлөө</i> .....	34
<i>Бизнес эрхлэгчдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шаардагдах дэмжлэг</i> .....	36
<i>Хоёрдугаар хэсгийн дүгнэлт</i> .....	39
II-3. Бизнес дэх ажиллах хүчний нөлөө, өөрчлөлт.....	40
<i>Бизнес дэх нөлөө</i> .....	40
<i>Бизнес эрхлэгчдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шаардагдах дэмжлэг</i> .....	42
<i>Гуравдугаар хэсгийн дүгнэлт</i> .....	43
II-4. Бизнес дэх ханган нийлүүлэлтийн сүлжээний нөлөө, өөрчлөлт.....	44
<i>Бизнес дэх нөлөө</i> .....	44
<i>Бизнес эрхлэгчдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шаардагдах дэмжлэг</i> .....	47
<i>Дөрөвдүгээр хэсгийн дүгнэлт</i> .....	49
II-5. Судалгаанд оролцогчдын мэдээлэл .....	50
<b>НЭГДСЭН ДҮГНЭЛТ</b> .....	<b>51</b>
<b>САНАЛ, ЗӨВЛӨМЖ</b> .....	<b>53</b>

**ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

Зураг I-1-1. БДНБ-ий өсөлт, уул уурхай ба уул уурхайн бус БДНБ-ий өсөлт .....	2
Зураг I-1-2. Уул уурхайн салбарын БДНБ-ий өсөлт, гол эрдэс бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба үнийн өсөлт .....	2
Зураг I-1-3. Уул уурхайн бус салбарын БДНБ-ий өсөлт, бусад салбарын хувь нэмэр .....	3
Зураг I-1-4. БДНБ-ий өсөлт, эрэлтийн бүрэлдэхүүнээр .....	3
Зураг I-1-5. Бүртгэлтэй ААНБ-ын тоо .....	4
Зураг I-1-6. Үйл ажиллагаа явуулж буй ААНБ, салбараар .....	4
Зураг I-1-7. Татварын тайлан илгээсэн ААН-ийн тоо .....	5
Зураг I-1-8. Татварын тайлан илгээсэн ААН-ийн тоонд Х тайлан илгээсэн ААН-ийн эзлэх хувь, 2021 оны байдлаар (салбараар) .....	5
Зураг I-1-9. Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн статистик .....	6
Зураг I-1-10. Эдийн засгийн салбаруудын ажил эрхлэлт .....	6
Зураг I-1-11. Дундаж цалингийн өөрчлөлт, салбараар .....	7
Зураг I-2-1. Мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгагдсан зарим гол үзүүлэлт .....	9
Зураг I-2-2. Инфляц, бодлогын хүү ба мөнгөний нийлүүлэлтийн өсөлт .....	9
Зураг I-2-3. Мөнгөний нийлүүлэлт, пассив тал .....	10
Зураг I-2-4. ХҮИ-ийн бүлгийн задаргаа .....	10
Зураг I-2-5. Үйлдвэрлэгчийн үнийн инфляц (аж үйлдвэр, уул уурхай, цахилгаан) .....	11
Зураг I-2-6. Нийт зээл ба чанаргүй зээлийн өсөлт .....	11
Зураг I-2-7. Банкны зээлийн үлдэгдлийн өсөлт, эдийн засгийн салбараар .....	12
Зураг I-2-8. Банкны шинээр олгосон зээлийн өсөлт, эдийн засгийн салбараар .....	12
Зураг I-2-9. Шинээр олгосон зээл, шинээр татсан хадгаламжийн ЖДХ .....	13
Зураг I-3-1. Төсвийн орлого, зарлага, тэнцэл .....	15
Зураг I-3-2. Төсвийн орлого, бүрэлдэхүүнээр .....	15
Зураг I-3-3. Төсвийн зарлага, бүрэлдэхүүнээр .....	16
Зураг I-3-4. Нийгмийн даатгалд даатгуулагчид .....	16
Зураг I-3-5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зардал .....	17
Зураг I-3-6. Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо, олгосон мөнгөн дүн .....	17
Зураг I-4-1. Төлбөрийн тэнцэл, урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл .....	19
Зураг I-4-2. Нийт гадаад өрийн үлдэгдэл .....	19
Зураг I-4-3. ГШХО орох урсгал, салбараар .....	20
Зураг I-4-4. Гадаад худалдааны тэнцэл, сар тус бүрээр .....	20
Зураг I-4-5. Экспортын бүрдэл .....	21
Зураг I-4-6. Импортын бүрдэл .....	21
Зураг I-4-7. Гол эрдэс бүтээгдэхүүний экспортын жилийн өсөлт .....	21
Зураг I-4-8. Гадаад худалдааны нөхцөлийн индекс .....	22
Зураг I-4-9. ГВАН ба ам.долларын ханшийн өөрчлөлт .....	22
Зураг I-5-1. Өрхийн орлого, зардал, хэрэглээний өсөлт .....	24
Зураг I-5-2. Ядуурлын үндсэн үзүүлэлт .....	24
Зураг I-5-3. Дундаж орлого, хүн амын бүлгээр (ам.доллар) .....	24
Зураг II-1-1. Бизнес эрхлэгчдийн цар тахлын хүндрэлээс эргэн сэргэсэн байдал .....	29
Зураг II-1-2. Бизнес сэргэлтийн түвшин, салбараар .....	30
Зураг II-1-3. Бизнес бүрэн сэргэхэд нөлөөлж буй хүчин зүйлс .....	30
Зураг II-1-4. Бизнес бүрэн сэргэхэд нөлөөлж буй хүчин зүйлс, салбараар .....	31
Зураг II-1-5. Цар тахлын бизнест хамгийн гол нөлөөлсөн хүчин зүйлс .....	32
Зураг II-1-6. Цар тахлын бизнест хамгийн гол нөлөөлсөн хүчин зүйлс, салбараар .....	32
Зураг II-1-7. Бизнест ОХУ-Украины нөхцөл байдал нөлөөлсөн байдал .....	32
Зураг II-2-1. Бизнест үнийн өсөлтийн дарамт ирж байгаа давтамж, салбараар .....	34
Зураг II-2-2. Бизнест үнийн өсөлтийн дарамт мэдрэгдэж буй хугацаа .....	34
Зураг II-2-3. Бизнест үнийн өсөлтийн дарамт хамгийн ихээр нөлөөлж буй хэсгүүд .....	34
Зураг II-2-4. Бизнест үнийн өсөлтийн дарамт хамгийн ихээр нөлөөлж буй хэсгүүд, салбараар .....	35

Зураг II-2-5. Үнийн өсөлтийн бизнесийн ашигт нөлөөлсөн хувь.....	35
Зураг II-2-6. Үнийн өсөлтийн үед бизнес эрхлэгчдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.....	36
Зураг II-2-7. Үнийн өсөлтөөс шалтгаалан хамгийн эхэнд бууруулж буй зардлын төрлүүд.....	36
Зураг II-2-8. Бизнес дэх үнийн өсөлтийн сөрөг нөлөөг бууруулахад шаардлагатай дэмжлэг.....	36
Зураг II-2-9. Бизнес дэх үнийн өсөлтийн сөрөг нөлөөг бууруулахад шаардлагатай дэмжлэг.....	37
Зураг II-2-10. Зээл авах хүсэлт илгээсэн, холбогдсон байгууллагууд.....	38
Зураг II-2-11. Зээл авахад тулгарч буй бэрхшээл.....	38
Зураг II-2-12. Гадаад төлбөр тооцоо хийхтэй холбоотой хүндрэл байгаа эсэх.....	38
Зураг II-3-1. Цар тахлын өмнөх үетэй харьцуулахад ажиллагсдын тооны өөрчлөлт.....	40
Зураг II-3-2. Шаардагдах мэргэжлийн ажиллах хүч байгаа эсэх, салбараар.....	40
Зураг II-3-3. Бизнес дэх ажиллах хүчний хомсдолын нөлөө.....	41
Зураг II-3-4. Ажиллах хүчний хомсдолын нөлөө, аж ахуйн нэгжийн хэмжээгээр.....	41
Зураг II-3-5. Цалингийн зардлын дундаж өөрчлөлт.....	42
Зураг II-3-6. Бизнес шаардагдах мэргэжлийн ажиллах хүчийг олж ажиллуулах, ажлын байр нэмэгдүүлэхэд шаардагдах дэмжлэг.....	42
Зураг II-3-7. Бизнес шаардагдах мэргэжлийн ажиллах хүчийг олж ажиллуулах, ажлын байр нэмэгдүүлэхэд шаардагдах дэмжлэг, аж ахуй нэгжийн орлогын түвшнээр.....	42
Зураг II-4-1. Ханган нийлүүлэлтийн сүлжээний тасалдлын бизнес дэх нөлөө, салбараар.....	44
Зураг II-4-2. Танай бизнест ханган нийлүүлэлтийн сүлжээ тасалдсан уу?.....	44
Зураг II-4-3. Ханган нийлүүлэлт тасалдаж байгаа үндсэн шалтгаан.....	45
Зураг II-4-4. Бизнес ханган нийлүүлэлт тасалдсан нь хэрхэн нөлөөлж байгаа тухайд.....	45
Зураг II-4-5. Ханган нийлүүлэлтийн түнш орнууд.....	45
Зураг II-4-6. Ханган нийлүүлэлтийн тасалдлаас шалтгаалан зардлын өөрчлөлт.....	46
Зураг II-4-7. Ханган нийлүүлэлтийн тасалдлаас шалтгаалан бараа материал хүлээн авах хугацааны өөрчлөлт.....	46
Зураг II-4-8. Ханган нийлүүлэлтийн тасалдлыг бизнесүүд хэрхэн шийдвэрлэж байгаа тухайд.....	47
Зураг II-4-9. Бизнесүүд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түнш орнуудаар.....	47
Зураг II-4-10. Бизнес дэх ханган нийлүүлэлтийн тасалдлын сөрөг нөлөөг бууруулах чиглэлд авч хэрэгжүүлж болох дэмжлэг, арга хэмжээ.....	48
Зураг II-5-1. Судалгаанд оролцсон байгууллага, салбараар.....	50
Зураг II-5-2. Жилийн борлуулалтын орлого.....	50
Зураг II-5-3. Ажиллагсдын тоо.....	50

## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт I-6-1. Монгол улсын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл.....	26
--	----

## ӨМНӨХ ҮГ

МҮХАҮТ-ын нэг гол чиг үүрэг нь бодлогын өмгөөлөл, нөлөөллийн үйл ажиллагаа байдаг бөгөөд бизнесийн орчны өөрчлөлт, түүний үр нөлөөг тогтмол анхаарч судлах, бодлогын судалгаануудыг явуулах, судалгааны үр дүнд үндэслэн санал зөвлөмж боловсруулан бодлого шийдвэр гаргагч нарт хүргэдэг билээ.

Цар тахлын үр дагавраар улс төр, эдийн засаг, нийгэмд бий болсон хямрал нь шийдвэр гаргах уламжлалт байдлыг үндсээр нь өөрчилж байгаа энэ цаг үед улс орон, салбар, байгууллага аж ахуйн нэгжүүд тулгарсан асуудлуудыг шийдвэрлэх гарцыг хайхаас гадна өөрчлөлтийн боломжийг шинээр олж харах явдал чухал болж байна. Өнгөрсөн хоёр жилийн хувьд тээвэр логистик, хилийн боомтуудын дэд бүтэц, нэвтрүүлэх чадвар зэрэг нь бизнесийн орчны хамгийн тулгамдсан асуудлууд байсан бөгөөд эдийн засгийн өсөлтийг хязгаарлагч гол хүчин зүйлс болсоор байна.

МҮХАҮТ-аас цар тахлын дараах бизнесийн орчны нөхцөл байдлыг тодруулах зорилгоор 2022 оны 8 сарын 25-аас 9 сарын 4-ний өдрүүдэд цахим ба анкетын хэлбэрээр Улаанбаатар хот болон орон нутгийн нийт 1073 бизнес эрхлэгчдийг хамруулсан судалгаа явуулсан. Мөн Монгол улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийсэн болно. Судалгааны үр дүнд цар тахлын дараах бизнесийн нөхцөл байдал, бизнест тулгамдаж байгаа асуудлууд болон цаашид авах шаардлагатай дэмжлэгийн арга хэмжээнүүдийг гаргалаа.

Цар тахлын нөлөөгөөр дэлхий дахинаа бий болсон тээвэр логистик, ханган нийлүүлэлтийн сүлжээний хямрал болон Орос-Украины дайнтай холбоотойгоор үүссэн геополитикийн нөхцөл байдалд эдийн засгийг сэргээх, бизнесийг дэмжих, хэвийн үйл ажиллагааг хангахад төр хувийн хэвшил асуудлыг хамтран хэлэлцэх, төрөөс бизнесийг дэмжих, хамтран ажиллах нэн чухал байна.

МҮХАҮТ-аас танилцуулж буй “Цар тахлын дараах бизнесийн орчны судалгаа”-ны тайлан нь эдийн засаг бизнесийн орчинд тулгарч байгаа асуудлуудыг үнэлэх ба эрэмбэлэх, эдийн засаг бизнесийг сэргээх, сэргэлтийг хадгалж улмаар хөгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлох, хэрэгжүүлэх талаар оновчтой шийдвэр гаргахад тус дэм болно гэж найдаж байна.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ


## I. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

2020 онд БНХАУ-д гарсан коронавирусын халдвар нь дэлхийн эдийн засагт гэнэтийн цочир нөлөөг үзүүлэв. 2022 он гарч цар тахлын нөхцөл байдал намдаж эхэлсэн боловч ОХУ болон Украин хооронд үүссэн хурцадмал байдал нь гадаад худалдаа төдийгүй олон улсын санхүүгийн гүйлгээ, гадаад валютын арилжаанд гэнэтийн нөлөөг үзүүлэх боллоо. Хөрш 2 орноос дараалан учирсан гадаад шок монгол улсын макро эдийн засгийн орчинд хэрхэн нөлөөлсөн тухай товч танилцуулъя.

### I-1. Бодит сектор

2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон БДНБ-ий өсөлт 2022 оны II улирлын байдлаар 7.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.3 хувь, хагас жилийн нийт үйлдвэрлэл 12.7 их наяд төгрөг болж, эдийн засаг 1.9 хувь тэллээ. Уул уурхайн бус салбарын БДНБ өмнөх оны мөн үеэс 9.1 хувь өсөж, нийт өсөлтийг 8.1 нэгж хувиар нэмэгдүүлсэн бол уул уурхайн салбарын БДНБ 18.2 хувь буурч, 1.8 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлэв.


Зураг I-1-1. БДНБ-ий өсөлт, уул уурхай ба уул уурхайн бус БДНБ-ий өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2020 оны I улиралд БНХАУ-тай харилцах хилийн хөдөлгөөнийг хязгаарласнаар уул уурхайн салбар зогсонги байдалд орж байлаа.

Зураг I-1-2. Уул уурхайн салбарын БДНБ-ий өсөлт, гол эрдэс бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба үнийн өсөлт




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2020 оны 2 дахь хагас жилээс эхлэн “Ногоон гарц” түр журмыг хэрэгжүүлснээр нүүрсний экспортыг дэмжиж, “Алт-2” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх хөнгөлөлттэй санхүүжилтийг олгож эхэлснээр алт олборлолт эрчимжиж уул уурхайн салбарын агшилт удааширч эхлэв.

2021 эхний улиралд нүүрс олборлолт болон зэсийн хүдрийн агууламж сайжирснаар уул уурхайн салбар сэргэж эхэлсэн боловч уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр удаан, Оюу толгойн ил уурхайгаас олборлож буй зэсийн баяжмал, болон үүнд агуулагдах зэс, алтны агууламж 2022 он гарсаар төлөвлөгөөний дагуу буурч эхэлсэн нь сүүлийн 3 улирал дараалан уул уурхайн салбар агших шалтгаан болжээ.

2022 оны II улиралд уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл өсөхөд хөдөө аж ахуй, бөөний болон жижиглэн худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт голлон нөлөөлжээ.

Зураг I-1-3. Уул уурхайн бус салбарын БДНБ-ий өсөлт, бусад салбарын хувь нэмэр




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Цар тахлаас урьдчилсан сэргийлэх зорилгоор 2020 оны 11 сард бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон нь оны эцэст салбарын өсөлтийг удаашруулах нөлөө үзүүлсэн хэдий 2020 оны эхний 3 улирал ургац хураалт, мал төллөлт хэвийн байлаа. Цаг уурын таагүй нөхцөл байдлаас шалтгаалан хөдөө аж ахуйн салбар 2021 оны турш агшив. 2022 оны эхний хагас жилд малын зүй бус хорогдол өмнөх оны мөн үеэс 2.2 (90.9%) саяар буурч, тус салбар уул уурхайн бус салбарын нийт өсөлтөд 2.8 нэгж хувийн хувь нэмрийг оруулжээ.

Хилийн боомт дээр үүссэн ачаа тээврийн асуудал уул уурхай төдийгүй барилгын салбарт сөргөөр нөлөөлж, барилгын материалын нийлүүлэлт тасалдсанаар сүүлийн 2 жилд барилгын салбар агшилттай хэвээр байна.

Зураг I-1-4. БДНБ-ий өсөлт, эрэлтийн бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо


2021 оны эхний улирал НӨАТ-ын буцаан олголтоос шалтгаалж бүтээгдэхүүний цэвэр татварын орлого 2020 оны мөн үеэс 46.4 хувь өссөн байна. Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал, хөл хорионы нөлөөгөөр уналттай байсан худалдаа, үйлчилгээний салбар 2021 оны

сүүлийн хагас жилээс эхлэн сэргэж, уг сэргэлт 2022 онд импортын барааны НӨАТ-ын орлогыг нэмэгдүүлэх дам нөлөөтэй байлаа. Үр дүнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүтээгдэхүүний цэвэр татварын орлого 2022 оны I болон II улиралд харгалзан 9.8 хувь, 13.6 хувь өсжээ.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон эдийн засгийн өсөлт 2022 оны II улиралд өмнөх оны мөн үеэс 6.9 хувь өсөлттэй байна. Энэ өсөлтөд хөрөнгийн хуримтлал 26.5 нэгж хувийн зэрэг нөлөө үзүүлсэн бол цэвэр экспорт 23.8 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлжээ. 2021 онд хөл хориог шат дараатай суларсан, засгийн газар, төв банкнаас эдийн засгийг дэмжих хөнгөлөлттэй зээл, санхүүжилтийн арга хэмжээг хэрэгжүүлсэн нь хөрөнгийн хуримтлалын өсөлтийг хурдасгав.

Ковид-19 цар тахлын нөхцөл байдал шинээр бизнес эхлүүлэх үйл ажиллагааны өсөлтийг бууруулаагүй боловч, өсөлтийн хурдыг сааруулсан байна. 2022 оны I улирлын байдлаар бизнес регистрийн санд 231.3 мянган аж ахуй нэгж байгууллага бүртгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 12.4 хувь өссөн байна. Бүртгэлтэй нийт аж ахуй нэгжийн 41.9 хувь буюу 97.0 мянган аж ахуй нэгж үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.


Зураг I-1-5. Бүртгэлтэй ААНБ-ын тоо



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуй нэгжийн тоо 95.6 мянга буюу 2020 оны IV улиралд бүртгэлтэй аж ахуй нэгжийн 47.9 хувийг бүрдүүлж байсан бол цар тахлаас сэргийлэх зорилгоор дотоодод хөл хорио тогтоосноор 2021 оны эхний улиралд 91.7 мянга болж буурчээ. Энэ хугацаанд үйл ажиллагаагаа түр болон бүрэн зогсоосон аж ахуй нэгжийн тоог улирлаар тооцоход 2021 оны 4 улирлын дунджаар өмнөх оны мөн үеэс 29.8 хувь, 75.9 хувь өссөн байна.

Зураг I-1-6. Үйл ажиллагаа явуулж буй ААНБ, салбараар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо




Үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийг эдийн засгийн салбараар харьцуулахад 2021 оны бизнесийн орчны зогсонги байдалд хөдөө аж ахуй, уул уурхай, боловсролын салбар хамгийн ихээр өртсөн байна.

Цар тахлын халдвар хурдтай тархаж байсан нөхцөл байдлыг харгалзан боловсролын үйлчилгээг цахимаар хүргэсэн, нэг анги, танхимд хичээллэх суралцагчийн тоонд хязгаарлалт тогтоосон арга хэмжээ боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын бууралтыг тайлбарлаж байв.

Хилийн боомт, түүнтэй холбогдох тээврийн асуудал, БНХАУ-аас тогтоосон импортын тоо хэмжээний хязгаарлалт зэрэг нь уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжийн үйл ажиллагаа доголдох шалтгаан болов.

2021 оны сүүл үеэс эхлэн дотоодын хэрэглээний тал орчим хувийг бүрдүүлдэг импортын бүтээгдэхүүний эрэлт ихсэж, хил дээр үүсэж байсан тээвэр, логистикийн удаашралтай байдлыг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч эхэлсэн болоод нүүрсний экспорт сэргэж эхэлснээр тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжийн үйл ажиллагаа 2022 он гарснаар сэргэж, хэвийн болох хандлага ажиглагдаж байна.

Зураг I-1-7. Татварын тайлан илгээсэн ААН-ийн тоо



Эх сурвалж: Татварын ерөнхий газар

2019 оны байдлаар 112.8 мянган аж ахуй нэгж татварын тайлан илгээсний 44.1 хувь тайлант хугацаанд ямар нэг орлого, зарлага гаргаагүй буюу үйл ажиллагаа явуулаагүй болохыг илэрхийлж, X тайлан илгээсэн байна. Харин 2021 оны байдлаар тайлан илгээсэн аж ахуй нэгжийн тоо 145.3 мянга болж, 2019 оноос 28.8 хувь өссөн боловч X тайлан илгээсэн аж ахуй нэгжийн тоо 72.9 мянга болж 2 жилийн хугацаанд 46.6 хувь өсжээ.

2020 болон 2021 оны байдлаар татварын тайлан илгээсэн нийт аж ахуй нэгжийн 50.0 хувь нь үйл ажиллагаа эрхлээгүй буюу X тайлан илгээсэн байна.

Зураг I-1-8. Татварын тайлан илгээсэн ААН-ийн тоонд X тайлан илгээсэн ААН-ийн эзлэх хувь, 2021 оны байдлаар (салбараар)




Эх сурвалж: Татварын ерөнхий газар

2021 оны байдлаар Татварын тайлан илгээсэн нийт ААН-ийн тоонд X тайлан илгээсэн ААН-ийн эзлэх хувь Бусад үйлчилгээ (69%), Урлаг (66%), Хөдөө аж ахуй (64%), Удирдлагын болон дэмжлэгийн үйлчилгээ (58%), Төрийн удирдлага (58%), Уул уурхай (57%), Боловсрол (52%)–ын салбарт 50 хувиас дээш үзүүлэлтэй байгаа нь эдгээр салбарын аж ахуй нэгжийн үйл

ажиллагаа цар тахлын нөхцөл байдлаас үүдэлтэй бизнесийн салбарын зогсонги байдалд хамгийн их өртөж буйг илэрхийлнэ.

Сүүлийн 3 жилийн тоон мэдээллээс харахад 2021 оны I улиралд ажил эрхлэлтийн түвшин хамгийн бага түвшинд буюу 50.1 хувь болж буурав. Үүнд 2020 оны 11 сард тогтоосон хөл хорио гол нөлөөг үзүүлсэн ба 2021 оны эхний улиралд бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж, ажил эрхлэлтийн хэлбэрт өөрчлөлт орж, цахим болон ээлжээр ажиллах болсон, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа зогсонги төлөвт шилжсэн зэрэг эдийн засгийн идэвх суларснаас үүдэлтэй хөдөлмөрийн зах зээлийн хэв шинжид нөлөөлжээ.

Зураг I-1-9. Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн статистик




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Цар тахлын нөхцөл байдал дэлхий нийтээр намжиж, гадаад харилцаа идэвхжиж байгаа төдийгүй дотоодын үйлдвэрлэл аажмаар сэргэж, хөдөлмөрийн зах зээлийн идэвхийг нэмэгдүүлэх хандлагатай хэдий ч 2022 оны II улирлын ажил эрхлэлтийн түвшин 54.7 хувь, ажилгүйдлийн түвшин 7.8 хувь, хөдөлмөр дутуу ашиглалтын нийлмэл түвшин 11.4 хувь болж, 2021 оны эхний улиралд цар тахлын нөхцөл байдлаас үүдсэн хөдөлмөрийн идэвхгүй байдал аажмаар буурч байна.

Ажил эрхлэлтийн түвшин сүүлийн 5 жилийн хамгийн бага утгад хүрсэн 2021 оны I улиралд уул уурхай (-9.8%), боловсруулах (-11.0%), барилга (-12.9%), худалдаа (-14.6%), мэдээлэл холбоо (-54.0%), тээвэр (-31.3%) үйлчилгээний салбарт (-20.0%) ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс буурсан байна.


Зураг I-1-10. Эдийн засгийн салбаруудын ажил эрхлэлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Эдийн засгийн салбаруудын ажил эрхлэлт салбарын өсөлтөөс шууд хамаарч өөрчлөгдөж байна. Нийт ажил эрхлэлт 2022 оны II улиралд өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар өссөн боловч 2020 оны мөн үеэс 1.7 хувиар буурсан буюу цар тахлын нөлөөтэй уналтаас бүрэн сэргээгүй байна. 2022 оны II улиралд хөдөө аж ахуй (-1.4%), барилга (-2.4%), санхүүгийн үйлчилгээ (-20.8%), худалдааны салбар (-7.4%) өмнөх оны мөн үеэс буурсан, бусад салбар 2021 оны эхний улиралд тохиосон ажил эрхлэлтийн огцом бууралтыг аажмаар нөхөж байна.

Зураг I-1-11. Дундаж цалингийн өөрчлөлт, салбараар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2022 оны II улиралд дундаж цалин 1.54 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 16.1 хувь өслөө. Он гарснаар дундаж цалин хурдтай өсөж байгаа боловч гадаад сектороос хамаарч өсөлт удааширч буй барилга (12.4%), уул уурхайн салбарын (11.9%) дундаж цалин өсөлт хамгийн бага, худалдаа (21.4%), боловсруулах үйлдвэрлэл (19.1%), үйлчилгээний салбарын (18.1%) дундаж цалин хамгийн их өсөлттэй байна.

Бодит секторын онцлох дүгнэлт

- 2022 оны II улирлын бодит үйлдвэрлэл 7.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.3 хувь, хагас жилийн нийт үйлдвэрлэл 12.7 их наяд төгрөг болж, эдийн засаг өмнөх үеэс 1.9 хувь тэллээ. Эдийн засгийн өсөлтийг хөдөө аж ахуй, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт голлон бүрдүүлсэн бол БНХАУ-тай харилцах хилийн хөдөлгөөний хязгаарлалт, Оюу толгойн ил уурхайгаас олборлож буй зэсийн баяжмалын агууламж буурснаар уул уурхайн салбар агшиж, тээврийн асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй тул барилгын салбарын уналт 2 дахь жилдээ үргэлжилж байна.
- Эцсийн хэрэглээ талаас эдийн засгийн өсөлтөд хөрөнгийн хуримтлал гол хувь нэмрийг оруулав. 2021 оноос хөл хориог шат дараатай суллах, бодлого хэрэгжүүлэгч байгууллагаас эдийн засгийн өсөлтийг дэмжих хөнгөлөлттэй зээл, санхүүжилтийн арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хөрөнгийн хуримтлалын өсөлт хурдсаж байна.
- 2020 онд бүртгэлтэй аж ахуй нэгжийн 47.9 хувь буюу 95.6 мянга аж ахуй нэгж үйл ажиллагаагаа хэвийн явуулж байсан бол 2022 оны I улирлын байдлаар бизнес регистрийн санд 231.3 мянган аж ахуй нэгж бүртгэлтэй, үүний 41.9 хувь буюу 97.0 мянган аж ахуй нэгж үйл ажиллагаагаа явуулж байна.
- Үйл ажиллагаа хэвийн явуулж буй аж ахуй нэгжийг эдийн засгийн салбараар харьцуулахад 2021 оны бизнесийн орчны зогсонги байдалд хөдөө аж ахуй, уул уурхай, боловсролын салбар хамгийн ихээр өртсөн байна.
- Цар тахлын байдлаас үүдэлтэй эдийн засгийн идэвх суларч, 2021 оны I улиралд сүүлийн 5 жилийн хамгийн бага түвшинд хүрч байсан бол 2022 оноос хөдөлмөрийн зах зээл мөн сэргэж II улиралд ажил эрхлэлтийн түвшин 54.7 хувь, ажилгүйдлийн түвшин 7.8 хувь, хөдөлмөр дутуу ашиглалтын нийлмэл түвшин 11.4 хувь болж цар тахлын нөхцөл байдлаас үүдсэн хөдөлмөрийн идэвхгүй байдал аажмаар буурч байна.
- 2021 онд цар тахлын нөхцөл байдал уул уурхай, барилга, боловсруулах, худалдаа, үйлчилгээ, тээврийн салбарын ажил эрхлэлтэд хамгийн хүчтэй нөлөөлжээ.
- 2021 оны турш өсөлтийн хурд удааширч байсан дундаж цалингийн түвшин эдийн засгийн салбарын идэвх, сэргэлтийг хурдсах хандлагатай болов. 2022 оны II улиралд гадаад сектор, хилийн асуудлаас шалтгаалж өсөлт удааширч буй барилга, уул уурхайн салбарын дундаж цалингийн өсөлт хамгийн бага (12.1%), эрчимтэй сэргэж буй худалдаа, үйлчилгээний салбарын дундаж цалингийн өсөлт хамгийн их (19.8%) байна.

## 1-2. Мөнгө, санхүүгийн сектор

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2020 оноос эхлэн дунд хугацаанд хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцыг 6.0 хувь орчимд тогтворжуулах зорилтыг тавьж ажиллаж байна.


Зураг 1-2-1. Мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгагдсан зарим гол үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк

2022 оны II улиралд 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон БДНБ өмнөх оны мөн үеэс 6.3 хувь өсөж, төгрөгийн америк доллартой харьцах ханш улирлын дунджаар 3092.1 төгрөгт хүрч, төгрөгийн ханш өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар буурлаа.

Зураг 1-2-2. Инфляц, бодлогын хүү ба мөнгөний нийлүүлэлтийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Ковид-19 цар тахлын халдварыг хумих зорилгоор 2020 онд хөл хорио тогтоосноор гадаад зах зээлийн нөлөөгөөр хумигдаж байсан эдийн засгийн идэвхийг дахин сулруулж, зах зээлд оролцогчдын эрэлт буурч, эмнэлгийн бараа, үйлчилгээ болоод хатуу түлшнээс бусад хэрэглээ мэдэгдэхүйц буурч, инфляцын түвшин буурав.

ОХУ болон Украины дайны нөхцөл байдлаас үүдэн олон улсын санхүүгийн гүйлгээ саатах, БНХАУ-ын хэрэгжүүлж буй “Тэг-Ковид” бодлогын хүрээнд гадаад худалдааны хүндэрч болох эрсдэлтэй нөхцөл байдлаас үүдэн нийгэм, эдийн засагт үүсэх сөрөг үр дагаврыг бууруулах зорилгоор Монголбанкнаас цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж 6.0% болгон бууруулсан Мөнгөний бодлогын хүүг 2022 оны 1 сараас эхлэн үе шаттайгаар нэмлээ.

2021 оны I улирлаас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилттэй холбоотойгоор зээл олголт нэмэгдэж, мөнгөний нийлүүлэлт өссөн байна. 2022 он гарснаар инфляцын түвшин хурдацтай өсөж, 2022 оны 8 дугаар сарын

байдлаар 14.4 хувь хүрлээ. Инфляцыг зорилтот түвшинд тогтоох барих зорилгоор мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлж Монголбанкнаас бодлогын хүүг 10% хүртэл үе шаттайгаар нэмж, мөнгөний нийлүүлэлтийг хумьж байна.

Зураг I-2-3. Мөнгөний нийлүүлэлт, пассив тал




Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлтийг бүтцээр ангилан харвал 2022 оны 8 дугаар сард мөнгөний нийлүүлэлт 26.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.8 хувь буурсан ба банкнаас гадуурх бэлэн мөнгө 9.8 хувь, төгрөгийн хадгаламж 16.3 хувиар тус тус буурсан нь үг өөрчлөлтийн гол шалтгаан болжээ.

Инфляцын түвшин өндөр, ам.долларын ханш чангарч байгаа учир төгрөгийн харьцангуй өгөөж буурч, төгрөгийн харилцах, хадгаламжийн хэмжээ буурч байна. Сүүлийн 2 жил орчим хугацаанд 2'800 төгрөгийн түвшинд барьж байсан төгрөгийн америк доллартой харьцах ханш 2022 оноос огцом суларч эхэлснээр энэ хугацаанд гадаад валютын харилцах өмнөх оны мөн үеэс 55.2 хувь, гадаад валютын хадгаламж 11.1 хувиар өсжээ.

Зураг I-2-4. ХҮИ-ийн бүлгийн задаргаа




Эх сурвалж: Монголбанк

Дотоодын халдвар хамгааллын дэглэмийг үе шаттайгаар зөөллөсөн боловч цар тахлын тархалт өндөр хэвээр байсан нь өрхийн орлогын бууралт, тодорхой бус байдлаас үүдэлтэй хэрэглээг хумих хандлагаар 2021 оны эхний хагас жилд инфляцын түвшин зорилтот түвшний орчим хадгалагдаж, нам түвшинд байлаа. Энэ хугацаанд инфляцын өсөлт дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ өсөлтийг дагаж дотоодод үүссэн шатахууны үнийн өсөлтөөр тайлбарлагдана.

Хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцыг хэрэглээний бүлгээр задалж, харьцуулахад 2021 оны сүүлийн хагас жилд малын гоц халдвар өвчин тархаж, махны нийлүүлэлтээс үүдэлтэй үнийн өсөлтийг бий болгож, Замын-үүд боомтын саатлаас шалтгаалж хүнсний бүтээгдэхүүний импортын үнэ өсөж, гадаад зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлтөөр дотоод дахь шатахууны үнийн өсөлт хурдсаж, инфляцын түвшин оны эцэст 13.4 хувь хүрлээ.

2022 он гарснаар ОХУ ба Украин хоорондын дайнаас үүдэлтэй европ тивээр дамжин тээвэрлэдэг барааны үнэ огцом өсөж, Европын холбоо болоод дэлхийн бусад улс орноос ОХУ-ын эсрэг хориг тавих бодлого хэрэгжүүлж байгаа нь бараа, үйлчилгээний төлбөр, тооцоо саатах, удаашрах нөхцөл байдлыг үүсгэж, импортын үнэ өсөж, инфляцыг өсгөсөөр байна.


Зураг I-2-5. Үйлдвэрлэгчийн үнийн инфляц (аж үйлдвэр, уул уурхай, цахилгаан)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Үйлдвэрлэгчийн үнийн индексээр тооцсон инфляцад тээврийн зардлын өсөлтөөс үүдэлтэй уул уурхайн салбарын үнийн өсөлт, төгрөгийн ханш суларсан байдал, импортын үнийн өсөлтөөс үүдэлтэй дотоодын үйлдвэрлэлд ашиглагдаж буй орц, материалын үнийн өсөлт гол нөлөөг үзүүлжээ.

Зураг I-2-6. Нийт зээл ба чанаргүй зээлийн өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


2020 онд цар тахлын нөлөөгөөр зээл олголт зогсох төлөвтэй болсон хэдий ч 2021 оны I улирлаас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилттэй холбоотойгоор зээл олголт нэмэгдэв.

Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсэж 2020 оны IV болон 2021 оны I улиралд чанаргүй зээлийн үлдэгдэл 2.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10.0 хувь өсөөд байв. Монголбанкнаас 2021 оны эхний хагасаас эхлэн цар тахлын

нөхцөл байдалд чиглэсэн дараах зохицуулалтыг хэрэгжүүлснээр чанаргүй зээлийн хэмжээ 2021 оны II улирлаас эхлэн буурав. Эдгээр арга хэмжээ нь:


- Хэрэглээний зээлийн эргэн төлөлт нь хүндрэлд орсон тохиолдолд зээлийн төлөлтийг 12 хүртэлх сараар сунгах,
- Эргэн төлөлтийн доголдолд орсон зээлийн ангиллыг түр хугацаанд бууруулахгүй байх асуудлыг банкнууд бие даан шийдвэрлэх,
- Ипотекийн зээлийн эргэн төлөлтийг 12 хүртэлх сараар хойшлуулах зэрэг болно.

Зураг I-2-7. Банкны зээлийн үлдэгдлийн өсөлт, эдийн засгийн салбараар



2022 оны I улирал хүртэлх 5 улирал дараалан өссөн зээлийн үлдэгдлийн өсөлт 2022 оны 5 дугаар сараас удааширч эхлэв. 2022 оны 8 дугаар сард уул уурхайн салбарын зээл өмнөх оны мөн үеэс 12.3 хувиар буурч, худалдааны салбарын зээл 35.0 хувь өсөж, бусад салбарт банкаас олгосон зээлийн үлдэгдэл 7.0-16.9 хувийн өсөлттэй байна.

Зураг I-2-8. Банкны шинээр олгосон зээлийн өсөлт, эдийн засгийн салбараар




Монголбанкны “Банкны зээлийн төлөв” түүвэр судалгаанаас харахад эх үүсвэрийн зардал өсөж, барьцаа хөрөнгийн эрсдэл нэмэгдэж, эдийн засгийн нөхцөл байдал муудсан нь 2022 оны II улиралд зээл олголт буурахад нөлөөлөв. 2022 оны 8 дугаар сард 2.5 их наяд төгрөгийн зээлийг шинээр олгосон ба энэ нь өмнөх оны мөн үеэс 2.6 хувийн өсөлттэй үзүүлэлт юм.

2022 оны 8 дугаар сард хөдөө аж ахуйн салбарт олгосон зээл 25.6 хувь, худалдааны салбарт олгосон зээл 49.0 хувь өмнөх оны мөн үеэс өссөн боловч барилгын салбарт шинээр олгосон зээл 56.0 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбар 33.5 хувь тус тус буурснаар шинээр олгосон зээлийн өсөлт саарсан байна.



Зураг I-2-9. Шинээр олгосон зээл, шинээр татсан хадгаламжийн ЖДХ



Эх сурвалж: Монголбанк

2022 оны 6 сард Мөнгөний бодлогын хүүг 10.0 хувь болгон өсгөх шийдвэрийн нөлөөгөөр 7 сараас эхлэн төгрөгийн хадгаламжийн хүү 2021 оны 12 сараас 2.5 функт өсөж 8.3% болов. Банкны шинээр олгож буй зээлийн хэмжээ буурч байгаагаас шалтгаалан шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 14.0-15.0 хувийн хооронд тогтвортой хэвээр байна.




### Мөнгө, санхүүгийн секторын онцлох дүгнэлт

- 2021 онд “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилттэй холбоотойгоор зээл олголт нэмэгдэж, мөнгөний нийлүүлэлт өсөв.
- 2021 онд махны нийлүүлэлтийн дутагдал, Замын-үүд боомтын саатлаас шалтгаалж хүнсний бүтээгдэхүүний импортын үнэ өсөж, гадаад зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлтөөр дотоод дахь шатахууны үнийн өсөлт хурдсаж, инфляцын түвшин оны эцэст 13.4 хувь хүрлээ.
- 2022 оны 8 сард инфляц 14.4 хувь хүрч, Монголбанкнаас инфляцыг зорилтот түвшинд тогтоох барих зорилгоор мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлж, бодлогын хүүг 10.0 хувь хүртэл үе шаттайгаар нэмж, мөнгөний нийлүүлэлтийг хумьж байна.
- Бодлогын хүүг 10.0 хувиар тогтоох шийдвэрт ОХУ болон Украины хурцадмал нөхцөл байдлаас үүдэн олон улсын санхүүгийн гүйлгээ саатах, БНХАУ-ын хэрэгжүүлж буй “Тэг-Ковид” бодлогын хүрээнд гадаад худалдааны хүндэрч болох эрсдэл нөлөөлжээ.
- Инфляцын түвшин өндөр, ам.долларын ханш чангарч байгаа учир төгрөгийн харьцангуй өгөөж буурч, төгрөгийн харилцах, хадгаламжийн хэмжээ буурч байна.
- 2022 оны II улирлаас эхлэн банкнуудын шинээр олгох зээлийн өсөлт удааширч, нийт зээлийн үлдэгдэл буурав. Энэ хугацаанд хөдөө аж ахуй, худалдааны салбарт шинээр олгосон зээлийн хэмжээ өсөж, уул уурхай, боловсруулах, үл хөдлөх, барилгын салбарт шинээр зээл олголт буурсан байна.
- Мөнгөний бодлогын хүүг өсгөх шийдвэрийн хүрээнд банкнуудын шинээр татаж буй хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 8.3 хувь болж өссөн бол шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү тогтвортой хэвээр байна.

### I-3. Засгийн газрын сектор

2022 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 17.7 хувиар өсөж 10.0 их наяд төгрөгт, төсвийн зарлага 14.3 хувиар өсөж 10.9 их наяд төгрөгт хүрч, төсвийн тэнцэл 899.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Зураг I-3-1. Төсвийн орлого, зарлага, тэнцэл




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2020 болон 2021 онд цар тахлын үед иргэд, аж ахуй нэгжүүдийг дэмжих чиглэлээр төсвийн шинжтэй арга хэмжээнүүдийг идэвхтэй хэрэгжүүлсэн нь 2020 онд гол төлөв төсвийн орлогыг бууруулах нөлөөг, 2021 онд төсвийн зардлыг өсгөж, төсвийн дарамтыг нэмэгдүүлэв. Эдгээр үйл ажиллагаанаас дурдвал:

- 2020 оны 4 сараас эхлэн “Хүүхдийн мөнгө хөтөлбөр”-ийн хүрээнд олгож буй мөнгөн тэтгэмжийн хэмжээг 100'000 төгрөг болгон нэмэгдүүлсэн,
- 2020 оны 4 сараас 2021 оны 6 сарыг хүртэлх хугацаанд орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг чөлөөлсөн,
- 2021 оны 7 сараас 2021 оныг дуустал нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулсан,
- 2021 оны 5 дугаар сард тогтоосон хөл хорионы үеэр иргэн бүрд 300'000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон,
- 2021 оныг дуустал айл өрхийг цахилгааны төлбөрөөс чөлөөлсөн,
- Ковид-19 цар тахлын халдвараас сэргийлэх вакцины 2 тунд хамрагдсан иргэдэд 50'000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшуулал олгосон эдгээр болно.

Зураг I-3-2. Төсвийн орлого, бүрэлдэхүүнээр




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

“Оюу толгой” компанийн татварын маргаантай холбоотой 1.0 их наяд төгрөгийг 2021 оны 4 дүгээр сард татварын бус орлогод нэмж бүртгэсэн нь 2021 оныг дуустал татварын бус орлогын өсөлтийг бодит байдлаас нэмэгдүүлж харуулж байв.

2022 оноос эхлэн нийгмийн даатгалын шимтгэлийг 2 хувиар хөнгөлж байсныг зогсоосон, Ирээдүйн өв санд хуваарилсан хөрөнгийг төсвийн тэнцвэржүүлсэн орлогод оруулж тооцсоны үр дүнд төсвийн тэнцвэржүүлсэн орлого өссөн байна.

Зураг I-3-3. Төсвийн зарлага, бүрэлдэхүүнээр




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2022 оны 8 сарын байдлаар төсвийн зарлага 10.9 их наяд төгрөг байгаа ба үүний 9.0 их наяд төгрөгийг урсгал зардал (82.3%), 1.8 их наяд төгрөгийг хөрөнгийн зардал (16.9%), 87.9 тэрбум төгрөгийг эргэн төлөгдөх цэвэр зээл (0.8%), бүрдүүлж байна. Ковид-19 цар тахлын үед айл өрхийн орлого, хэрэглээг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 2020 оноос эхлэн төсвийн зардал, тэр дундаа урсгал зардал хурдтай өсөж байна.

2022 оны 8 сарын байдлаар урсгал зардлын хэмжээ өмнөх оны мөн үеэс 14.3 хувь буюу 1.4 их наяд төгрөгөөр өсөхөд 2022 оны 2 дугаар сараас тэтгэврийн доод хэмжээг өсгөж, тэтгэврийг 15 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гол нөлөөг үзүүлээ.

Зураг I-3-4. Нийгмийн даатгалд даатгуулагчид




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Засгийн газраас цар тахалтай холбогдуулан 2020 оны 4 сараас 10 сар хүртэлх хугацаанд сайн дураар даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг хөнгөлсний үр дүнд тухайн онд сайн дураар даатгуулагчийн тоо буураагүй эерэг нөлөөтэй байлаа. Хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих зорилгоор 2020 оны 4 сараас 2021 оны 6 сарыг дуустал албан журмаар даатгуулагч хувь хүнийг орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтөөс чөлөөлснөөр 2021

оны II улиралд сайн дураар даатгуулагчийн тоо 136.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 13.1 хувиар буурав. Хөдөлмөрийн зах зээл сэргэж, ажил эрхлэлт цар тахлын өмнөх түвшинд хүрэх хандлагатай байгаа нь нийгмийн даатгалд даатгуулагчийн тоог нэмэгдүүлэх, ялангуяа сайн дураар даатгуулагчийн тооны бууралтыг сааруулах хандлагатай байна. 2022 оны 8 дугаар сард нийгмийн даатгалд даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 7.6 хувь өсөж 1.1 сая болжээ.

Зураг I-3-5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зардал



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Засгийн газраас цар тахалтай холбогдуулан хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих зорилгоор 2020 оны 4 сараас 2021 оны 6 сарыг дуустал орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтөөс чөлөөлж, 2020 оныг дуустал цар тахлын улмаас үйл ажиллагаа зогссон, борлуулалтын орлого нь 50 хувиас дээш буурсан аж ахуйн нэгжийн даатгуулагчдад ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200 мянган төгрөгийн дэмжлэг олгосноор 2020 оны сүүлийн 3 улирал нийгмийн даатгалын сан алдагдалтай ажиллав.

2021 онд нийгмийн даатгалын сангийн орлого, зардлын зөрүү багассан боловч 2021 оны 7 дугаар сараас эхлэн 2021 оныг дуустал нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулсан, хөдөлмөрийн зах зээлийн идэвх суларч, ажилгүйдлийн тоо өссөнөөр ажилгүйдлийн тэтгэмжийн зардал өссөн зэрэг шалтгаанаар цар тахлын өмнөх үеийн түвшинд хүрч чадаагүй байна.

Зураг I-3-6. Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо, олгосон мөнгөн дүн



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2022 оны 8 сард 2644 хүнд 5.8 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг олгож, тэтгэмж авсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 16.0 хувь өсөж, ажилгүйдлийн тэтгэмжийн мөнгөн дүн 58.7 хувь нэмэгдэв. 2021 оны 7 дугаар сараас “Ажилгүйдлийн сангаас тэтгэмж олгох журам”-ийн шинэчлэлийг мөрдөж эхэлснээр ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтийг цахимаар гаргах боломжтой болж, ажилгүйдлийн тэтгэмжийн хамрах хүрээ өсөх хандлага ажиглагдаж байна.


Засгийн газрын секторын онцлох дүгнэлт

- 2022 оны 8 дугаар сард улсын төсвийн тэнцэл 899.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. 2022 оны 2 сараас тэтгэврийн доод хэмжээг өсгөж, тэтгэврийг 15 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн нь урсгал зардал өсөх гол нөлөөг үзүүлэв.
- “Оюу толгой” компанийн татварын маргаантай холбоотой 1.0 их наяд төгрөгийг 2021 оны 4 дүгээр сард татварын бус орлогод нэмж бүртгэсэн нь 2021 оныг дуустал татварын бус орлогын өсөлтийг бодит байдлаас нэмэгдүүлж харуулж байв.
- Цар тахлын үед иргэд, аж ахуй нэгжүүдийг дэмжих чиглэлээр төсвийн шинжтэй арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлсэн нь 2020 онд төсвийн орлогыг бууруулах, 2021 онд төсвийн зардлыг өсгөх нөлөөтэй байлаа. Эдгээр арга хэмжээ нь:
  - 2020 оны 4 сараас эхлэн “Хүүхдийн мөнгө хөтөлбөр”-ийн хүрээнд олгож буй мөнгөн тэтгэмжийн хэмжээг 100'000 төгрөг болгон нэмэгдүүлсэн,
  - 2020 оны 4 сараас 2021 оны 6 сарыг хүртэлх хугацаанд орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг чөлөөлсөн,
  - 2021 оны 7 сараас 2021 оныг дуустал нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулсан,
  - 2021 оны 5 дугаар сард тогтоосон хөл хорионы үеэр иргэн бүрд 300'000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон,
  - 2021 оныг дуустал айл өрхийг цахилгааны төлбөрөөс чөлөөлсөн,
  - Ковид-19 цар тахлын халдвараас сэргийлэх вакцины 2 тунд хамрагдсан иргэдэд 50'000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшуулал олгосон зэрэг болно.
- Хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих зорилгоор засгийн газраас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд ажилгүйдлийн тэтгэмжийн хүртээмж сайжирч, нийгмийн даатгалд даатгуулагчийн тоонд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй хэдий ч нийгмийн даатгалын сан алдагдалтай байлаа.

### I-4. Гадаад сектор

2022 оны II улиралд урсгал тэнцэл 879.8 сая ам.доллар, санхүүгийн тэнцэл 499.6 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгийн тэнцэл 58.4 сая ам.долларын ашигтай байсан нь төлбөрийн тэнцэл 104.4 сая ам.долларын алдагдалтай буюу өмнөх оны мөн улирлаас 46.5 хувь сайжирсан боловч 2022 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцэл 1.1 тэрбум ам.долларын алдагдалтай байна.

Зураг I-4-1. Төлбөрийн тэнцэл, урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл



Эх сурвалж: Монголбанк

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020 оны сүүлийн хагаст эдийн засгийн идэвх суларч, хилийн боомтын асуудлаас шалтгаалж импортын хэмжээ огцом буурч, экспортын хэмжээ өмнөх оны түвшинд байснаар урсгал тэнцлийн алдагдал агшив. Энэ хугацаанд Оюу толгой болон бусад гадаадын хөрөнгө оруулалтай компанийн ГШХО-ын цэвэр орох урсгал буурсан, Засгийн газрын урт хугацаат гадаад зээлийн орох урсгал нэмэгдсэн зэрэг үйл явдал 2020 оны IV улирлын байдлаар санхүүгийн тэнцэл 981.4 сая ам.долларын алдагдалтай болов.

Зураг I-4-2. Нийт гадаад өрийн үлдэгдэл




Эх сурвалж: Монголбанк

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020, 2021 онд төрөөс хэрэгжүүлсэн мөнгөн тусламж, тэтгэмж, орлогын татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт зэрэг арга хэмжээний үр дүнд төсвийн алдагдал нэмэгдэж, уг алдагдлыг санхүүжүүлэх шаардлагаар Засгийн газрын өр 2020 оны II улирлаас эхлэн 2021 оны II улирал хүртэл тасралтгүй өсөв.

2023-2024 онд Засгийн газар МУХБ болон бусад гадаад зах зээлээс татсан бондын үндсэн төлбөрийг хийхээр хүлээгдэж байгаа нь цаашид төсвийн алдагдлыг үлэмж нэмэгдүүлэх төдийгүй гадаад валютын албан нөөцийг бууруулах төлөвтэй байна.

Өмнө гаргасан бондыг хөрөнгө оруулалт хэлбэрээр бус нийгмийн халамж хэлбэрээр гол төлөв ашигласнаар гадаад зах зээлээс дахин санхүүжилт авах зардал өссөөр байна.


Зураг I-4-3. ГШХО орох урсгал, салбараар



Эх сурвалж: Монголбанк

2020 онд IV улирал болон 2021 оны эхний хагаст хөл хорио тогтоосон нь аялал жуулчлал, үйлчилгээний салбарын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж, 2021 оны эхний хагас жилд тус салбарын ГШХО огцом буурлаа. Түүнчлэн 2021 оны I улиралд гадаад зах зээлд нүүрсний үнэ өссөн, нүүрсний тээврийн саад бэрхшээл багасаж, тул уурхайн салбарын томоохон компанийн ашигт ажиллагаа нэмэгдэж, тус салбарын ГШХО өсөв. Энэ оны эцсээр ГШХО-ын түвшин болоод санхүүгийн тэнцлийн гүйцэтгэлд Оюу толгой компанийн газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын хүрээнд орж ирэхээр хүлээгдэж буй санхүүжилт голлон нөлөөлөхөөр байна.

Зураг I-4-4. Гадаад худалдааны тэнцэл, сар тус бүрээр




Эх сурвалж: Монголбанк

Монгол улс 2022 оны 8 сарын нийт экспорт 7.6 тэрбум ам.доллар хүрч, өмнөх оны мөн үеэс 2.2 (38.7%) тэрбум ам.доллараар, импорт 5.6 тэрбум ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 1.1 (25.2%) тэрбум ам.доллараар тус тус өсжээ. Гадаад худалдааны тэнцэл 2022 өмнөх оны мөн үеэс 92.6 хувь буюу 1.0 тэрбум ам.доллараар өссөн боловч уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ бууралттай байна.

Европын холбооны улсууд ОХУ-аас нүүрс импортлохгүй, хориг тавьсан төдийгүй коронавирус цар тахлаас үүдэлтэй бүрэн болон хэсэгчилсэн хөл хорио тавих тохиолдлууд гарсаар байгаа нь олон улсын хэмжээнд нүүрсний эрэлтээс үүдэлтэй үнийн өсөлтийг бий болгож байна.




Зураг I-4-5. Экспортын бүрдэл



Эх сурвалж: Монголбанк

Зураг I-4-6. Импортын бүрдэл



Эх сурвалж: Монголбанк

Монгол улсын Засгийн газраас цар тахлын нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх хүрээнд 2020 оны 1 дүгээр сард гадаад худалдааны хамгийн том түнш болох БНХАУ-тай харилцдаг хилийн хөдөлгөөнийг хааснаар 2020 оны эхний хагас жилд экспорт өмнөх оны мөн үеэс 28.2%, импорт 15.0% тус тус буурав.

Засгийн газраас 2020 оны 3 сарын 23-ний өдрөөс БНХАУ-тай хийх нүүрсний худалдааны түр хоригийг цуцалсан боловч тээвэр хийж буй жолоочдод тавих эрүүл мэндийн шаардлага маш өндөр байгаа нь нүүрсний экспортыг удаашруулж байна.

Зэсийн экспортыг хэвийн үргэлжлүүлэх тухай БНХАУ болон Монгол улсын Засгийн газар тохиролцоонд хүрсэн хэдий ч 2020 оны эхний хагаст зэсийн баяжмалын үнэ 2019 оны 6 дугаар сарын дунджаас 321.4 сая ам.доллар, 2019 оны эцсээс 1.0 тэрбум ам.доллаароор тус тус буурсан байна.


Зураг I-4-7. Гол эрдэс бүтээгдэхүүний экспортын жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хорио, цээрийн дэглэм тогтоосон боловч уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг бууруулахгүй байх, хилийн боомтуудыг хэсэгчлэн нээх ажлыг үе шаттай хэрэгжүүлснээр 2021 оны эхний хагаст нүүрсний экспорт нэмэгдэв. дэлхийн нийт зэсийн хэрэглээний 40-50 хувийг хэрэглэдэг БНХАУ цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж эдийн засгийн өсөлт удааширч байсан бол 2020 оны сүүлийн сарууд болоод 2021 оны эхний саруудад эдийн засгаа хурдацтай сэргээснээр зэсийн эрэлт өсөж, үнэ өсөх шалтгаан болов.


Зураг I-4-8. Гадаад худалдааны нөхцөлийн индекс



Эх сурвалж: Монголбанк

2021 оны IV улиралд Эрээн, Замын-Үүдэд цар тахлаас сэргийлэх зорилгоор хийгдэж буй барааны ариутгал, тээвэрлэлт логистикийн дутагдалтай байдал, гаалийн баримт бүрдүүлэлтийн удаашралтай байдлаас шалтгаалж импортын барааны бөөгнөрөл үүсэж, импортын бараа хилээр орж ирэх хугацаа уртассан төдийгүй үнэ өсөж, импортын үнийн индекс 2022 оны 8 сард 119.7 болж, оны эхэн үеэс 2.1 хувиар өсөв.

Зураг I-4-9. ГВАН ба ам.долларын ханшийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн америк доллартой харьцах ханш 2022 оны 8 сарын дунджаар 3185.7 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.8% өслөө. 2022 оны 8 дугаар сарын байдлаар 2.69 тэрбум ам.доллар болж, 2017 оноос хойших доод түвшинд хэвээр байна.

Гадаад валютын нөөц буурч, гадаад валютын гарах урсгал нэмэгдэхэд Монгол улсын экспортын хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүртэл хангалттай сэргэж чадахгүй байгаа төдийгүй импортын барааны дотоод эрэлт нэмэгдэж байгаа нь нөлөөлж байна.

ОХУ болон Украины хурцадмал байдлаас шалтгаалан олон улсын санхүүгийн гүйлгээний SWIFT сүлжээнээс ОХУ-ын томоохон банкуудад хориг тавьснаар гадаад төлбөр тооцоо гүйцэтгэхэд хүндрэл учрав. Түүнчлэн дотоодод гадаад валютын нийлүүлэлт хязгаарлагдмал, эрэлт хангагдахгүй, гадаад зах зээлийн тодорхой бус байдал үргэлжилсэн хэвээр байсан тул арилжааны банкууд 2022 оны 4 сард рублийн гүйлгээг зогсоох, бусад валютын гүйлгээ, арилжааг 1 сая төгрөгөөр хязгаарлах, хэрэв валютын гүйлгээний дүн 1 сая төгрөгөөс давсан тохиолдолд банканд бичгээр хүсэлт гаргах зохицуулалтыг хийв. 2022 оны 5 сараас уг зохицуулалтыг сулруулж валютын гүйлгээний хязгаарыг 10-50 сая болгож тогтоосон байна.

### Гадаад секторын онцлох дүгнэлт


---

- 2022 оны эхний хагас жилийн байдлаар төлбөрийн тэнцэл 1.1 тэрбум ам.долларын алдагдалтай байв. 2023-2024 онд МУХБ болон бусад гадаад зах зээлээс татсан бондын үндсэн төлбөрийг хийхээр хүлээгдэж байгаа нь төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх, гадаад валютын албан нөөцийг бууруулах төлөвтэй байна.
- Цар тахлын нөхцөл байдал, хилийн асуудлаас шалтгаалан 2021 оны импортын хэмжээ буурснаар урсгал тэнцлийн алдагдал агшив. Эдийн засгийн идэвх суларч, Оюу толгой тэргүүтэй гадаадын хөрөнгө оруулалттай компанийн ГШХО-ын цэвэр орох урсгал буурч санхүүгийн тэнцэл алдагдалтай болов.
- Цар тахлын үед иргэд, аж ахуй нэгжүүдийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн тусламж, тэтгэмжийн арга хэмжээ улсын төсвийн алдагдлыг нэмэгдүүлж, уг алдагдлыг санхүүжүүлэх шаардлагаар 2020 оны II улирлаас эхлэн 2021 оны эхний хагасыг дуустал Засгийн газрын гадаад өр өсөв.
- Гадаад худалдааны тэнцэл 2022 оны 8 сарын нийт гүйцэтгэлээр 1.0 тэрбум ам.доллараар өссөн боловч уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ бууралттай байна.
- Европын холбооны улсууд ОХУ-аас нүүрс импортлохгүй, хориг тавьсан төдийгүй коронавирус цар тахлаас үүдэлтэй бүрэн болон хэсэгчилсэн хөл хорио тавих тохиолдлууд гарсаар байгаа нь олон улсын хэмжээнд нүүрсний эрэлтээс үүдэлтэй үнийн өсөлтийг бий болгож байна.
- 2020 оны 1 дүгээр сард гадаад худалдааны хамгийн том түнш болох БНХАУ-тай харилцдаг хилийн хөдөлгөөнийг хааж, тус оны 3 дугаар сараас БНХАУ-тай хийх нүүрсний худалдааны түр хоригийг цуцалсан боловч тээвэр хийж буй жолоочдод тавих эрүүл мэндийн шаардлага маш өндөр байгаа нь нүүрсний экспортыг удаашруулж байна.
- 2021 оны IV улиралд Эрээн, Замын-Үүдэд цар тахлаас сэргийлэх зорилгоор хийгдэж буй барааны ариутгал, тээвэрлэлт логистикийн дутагдалтай байдал, гаалийн баримт бүрдүүлэлтийн удаашралтай байдлаас шалтгаалж импортын барааны бөөгнөрөл үүсэж, импортын бараа хилээр орж ирэх хугацаа уртассан төдийгүй үнэ өссөн байна.
- Гадаад валютын албан нөөц 2022 оны 8 дугаар сарын байдлаар 2.69 тэрбум ам.доллар болж, 2017 оноос хойших доод түвшинд хэвээр байна. Дотоод зах зээлд гадаад валютын нийлүүлэлт хязгаарлалттай, гадаад худалдааны гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд хүртэл сэргэхгүй байгаа нь гадаад валютын нөөц буурч, төгрөгийн ам.доллартой харьцах ханшийг сулруулж байна.

### 1-5. Өрхийн үзүүлэлтүүд

2022 оны II улиралд өрхийн орлого 1.79 сая төгрөг, өрхийн зарлага 1.81 сая төгрөг болж өрхийн зарлага орлогоос сард дунджаар 23.7 мянган төгрөгөөр их байна.

Зураг 1-5-1. Өрхийн орлого, зардал, хэрэглээний өсөлт



Эх сурвалж: Монголбанк


2020 онд тогтоосон хөл хорионы дэглэм бизнесийн үйл ажиллагааг түр, бүрэн байдлаар зогсоож, ажил эрхлэлт, өрхийн орлогыг бууруулсан, Засгийн газар, Монголбанк хамтран ипотекийн орон сууцны зээлтэй иргэдийн зээл төлөлтийг 2022 оныг дуустал, 2021 оны I улиралд иргэдийн хэрэглээний зээлийн төлөлтийг 6 сар хүртэл хугацаагаар хойшлуулсан төдийгүй хилийн боомтын болоод тээврийн асуудлаар өргөн хэрэглээний бүтээгдэхүүний импорт удаашралтай байснаар 2021 оны I улиралд хугацаанд өрхийн орлого, зардал, хэрэглээ өмнөх оны мөн үеэс харгалзан 3.9 хувь, 6.7 хувь, 11.6 хувь тус тус буурав.

Зураг 1-5-2. Ядуурлын үндсэн үзүүлэлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 1-5-3. Дундаж орлого, хүн амын бүлгээр (ам.доллэр)



Эх сурвалж: World Inequality Lab

Ядуурлын хамралтын хүрээ буюу “Ядуурлын түвшин” 27.8 хувь байгаа нь ойролцоогоор 3 хүн тутмын 1 нь ядуу болохыг илэрхийлнэ. Ядуурлын гүнзгийрэлт 7.4 хувь буюу ядуу гэж тооцогдож буй хүн амын хэрэглээ амьжиргааны доод түвшнээс 7.4 хувь доогуур байна.

2021 оны байдлаар Монгол улсын нийт хүн амын хамгийн их орлоготой 10% нь дунджаар 71.1 мянган ам.долларын орлоготой байхад хамгийн бага орлоготой 50% нь дунджаар 5.0 мянган ам.долларын орлоготой байна. Хүн амын хамгийн өндөр орлоготой 10% нь хамгийн бага орлоготой 50%-аас дунджаар 15 дахин их орлоготой байна.

### Өрхийн үзүүлэлтийн онцлох дүгнэлт

---

- Цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан бизнесийн идэвх суларсан, ажил эрхлэлт, өрхийн орлого буурсан, өргөн хэрэглээний бүтээгдэхүүний импорт саарсан зэрэг шалтгаанаар өрхийн орлого, зардал, хэрэглээ 2021 оны дунд үеэр буурч, 2022 оны эхний улирлаас эхлэн өсөж байна.
- Монгол улсын нийт хүн амын 27.8 хувь нь ядуу гэж тооцогдох бөгөөд ядуу хүн амын хэрэглээ амьжиргааны доод түвшнээс 7.4 хувь бага байна.
- Хүн амын хамгийн өндөр орлоготой 10% нь хамгийн бага орлоготой 50%-аас дунджаар 15 дахин их орлоготой байна.

**I-6. Эдийн засгийн цаашдын төлөв**

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон Монгол банкнаас Монгол улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг 2022, 2023 онд дараах байдлаар төсөөлж байна.

Хүснэгт I-6-1. Монгол улсын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэлийн төсөөлөл			2023 оны гүйцэтгэлийн төсөөлөл		
	Монголбанк	Дэлхийн банк	АХБ	Монголбанк	Дэлхийн банк	АХБ
БДНБ-ий өсөлт (%)	2.5	2.5	2.3	5.9	5.8	5.6
Экспортын өсөлт (%)		4.0	1.3		18.0	14.5
Импортын өсөлт (%)		5.7	10.2		17.5	7.6
Инфляц (%)	12.0	10.5	12.4		7.5	9.3
Нэгдсэн төсвийн тэнцэл (ДНБ-ий хувиар), (%)		-4.8	-9.5		-4.8	-3.1

**Монголбанкны** төсөөллөөр Монгол улсын эдийн засаг 2022 онд 2.4 хувь, 2023 онд 5.9 хувь өсөх төлөвтэй байна. Оюу толгойн олборлох зэсийн баяжмал дахь алтны агууламж буурсан, хил боомтын хязгаарлалтаас үүдэлтэй экспортын бууралт зэрэг сөрөг нөлөөллөөс үүдэн уул уурхайн салбарын үйлдвэрлэл нийт дүнгээр буурах төлөвтэй байна.

БНХАУ-д цар тахлын тархалт энэ оны 2-р улиралд эрчимжиж, “Тэг-КОВИД” бодлогын хүрээнд томоохон хотуудад хатуу хөл хорио тогтоосон нь БНХАУ-ын хэрэглээ, аж үйлдвэрлэл, экспортод сөргөөр нөлөөлж өсөлтийн төлөв муудахад голлон нөлөөллөө. БНХАУ-ын эрх баригчид мөнгөний бодлогын төлөвийг оны сүүлийн хагаст үргэлжлүүлэн зөөлрүүлж, дотоод эрэлт, өсөлтийг дэмжиж 4.6 хувьд хүрэх хүлээлттэй байна.

Харин ОХУ-д цар тахлын тархалт бага байгаа ч ОХУ-Украины нөхцөл байдлаас үүдэлтэй ОХУ-д тавьсан хориг арга хэмжээний нөлөөгөөр дотоод эрэлт, үйлдвэрлэл буурах зэргээс үүдэн 2022 онд 9.5 хувиар агших төлөвтэй байна.

**Дэлхийн банкны** хувьд Монгол улс 2022 оны 2.5 хувь, 2023 онд 5.8 хувь өснө гэж таамаглаж байна. 2022 оны эдийн засгийн өсөлтөд цаг уурын таатай нөхцөл байдлын нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар, 2023 онд Оюу толгойн гүний уурхайн бүтээн байгуулалт, олборлолт голлон нөлөөлнө гэж үзжээ.

Хилийн боомтууд бүрэн хүчин чадлаар ажиллаж, тээвэр, логистикийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, 2022 оны сүүл рүү БНХАУ талаас цар тахалтай холбоотой хязгаарлалтуудаа бүрэн цуцалснаар экспортын нийт хэмжээ өсөх төлөвтэй байна. Хөдөлмөрийн зах зээлийн сэргэлт удаан, инфляцын түвшин өндөр байгаа нь өрхийн хэрэглээний өсөлтийг хязгаарлах боловч уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр импортыг нэмэгдүүлэх хүлээлттэй байна.

2023 онд Монгол Улсын Хөгжлийн Банкны 800 сая ам.долларын бондын эргэн төлөлтийг хийх ба гадаад валютын нөөц дутагдалтай, засгийн газрын гадаад өр их байгаа нь төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж, Монгол Улсын зээлжих зэрэглэл буурч, гадаад зах зээлээс санхүүжилт босгох зардал өсөх, нэгдсэн төсвийн алдагдал улам эрчимжих эрсдэл байна.

**Азийн хөгжлийн банк** Монгол улсын эдийн засгийн өсөлтийг 2022 онд 2.3 хувь, 2023 онд 5.6 хувь байхаар тооцжээ. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарын оруулах хувь нэмэр өсөлттэй хэвээр байх боловч уул уурхайн салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн үр дүнгээс шалтгаалж 2023-2025 оны эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөв тодорхойлогдохыг онцолж байна.

ОХУ, Украин хоорондын харилцаа 2023 онд хурцадмал хэвээр байх нь Монгол улс ба европын холбооны улс хоорондын санхүүгийн гүйлгээг удаашруулах, өрхийн хэрэглээнд сөргөөр нөлөөлөх төдийгүй шатахууны үнийн өсөлтийг нэмэгдүүлнэ. Шатахууны үнэ өндөр байгаагаас бизнес эрхлэх үйл ажиллагааны зардал өсөж, импортын барааны үнэ өсөхөөр байна. Төрийн өмчийн байгууллагын гадаад өрийн эргэн төлөлтүүд 2023-2024 онд хийгдэх хүлээлттэй байгаа нь төсвийн дарамтыг нэмэгдүүлэх, гадаад валютын нөөцийг бууруулах хүлээлттэй байна.

## II. ЦАР ТАХЛЫН ДАРААХ БИЗНЕСИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

МҮХАҮТ-аас цар тахлын дараах шинэ хэвийн нөхцөл байдалд бизнес эрхлэгчид хэрхэн дасан зохицон ажиллаж байна, үйл ажиллагаанд ямар өөрчлөлт сорилтууд тулгарч байгаа, цаашид ямар төрлийн дэмжлэг шаардагдаж байгааг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг явууллаа. Судалгааг 2022 оны 8 сарын 25-аас 9 сарын 4-ний өдрүүдэд цахим болон анкетын хэлбэрээр явуулж, Улаанбаатар хот болон орон нутгийн нийт 1073 бизнес эрхлэгчид оролцлоо.

### *Ерөнхий үр дүн*

#### **Бизнесийн нөхцөл байдал:**

- 2022 оны 9 сарын байдлаар судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 79% нь тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа бол 21% нь хэвийн, тогтвортой ажиллаж чадахгүй байна. Аж ахуйн нэгжүүдийн 86%-ийн үйл ажиллагаа нь ямар нэг түвшинд сэргэсэн ба дунджаар хүчин чадлынхаа 47.5% орчим хувийг ашиглан ажиллаж байна. Тээвэр, гадаад дотоод худалдаа, уул уурхай, аялал жуулчлал, барилгын салбарт “сэргэж чадаагүй” аж ахуйн нэгжийн тоо илүү олон байна. Цар тахал бизнесийн борлуулалт (61%), үйл ажиллагааны тасралтгүй байдал (48%), бараа бүтээгдэхүүн, нөөц хөрөнгөд (47%) хамгийн ихээр нөлөөлжээ;
- Үнийн өсөлт бизнес эрхлэгчдийн 96%-д нь тогтмол болон заримдаа давтамжтай сөрөг нөлөөтэй мэдрэгдэж байна. Үнийн өсөлтийн дарамт бизнес эрхлэгчдийн 43%-д нь сүүлийн хагас жилийн хугацаанд, 57%-д нь хагас жилээс дээш хугацаанд мэдрэгдэж, бизнесийн ашиг дунджаар 52%-аар буурсан байна. Бизнесийн үйл ажиллагаанд түүхий эд, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өссөн (70%), үйл ажиллагааны зардал өссөн (65%), цалин ажиллах хүчтэй холбоотой зардал өссөн (54%), борлуулалтын хэмжээ буурсан (50%) зэргээр үнийн өсөлт нөлөөлж байна;
- Бизнес эрхлэгчдийн 71% нь зээл авахаар аль нэг банк санхүүгийн байгууллага, хувь хүнд хандсан бөгөөд дөнгөж 27% нь зээлээ авч чадсан. Зээл авахад хүүгийн түвшин өндөр (75%), барьцаа хөрөнгийн шаардлага хангаж чадахгүй (59%), хугацаа хангалттай урт биш (50%) зэрэг хүндрэл үүсэж байна. Мөн бизнес эрхлэгчдийн 66% нь зээлийн олдоц муу байна гэж үзсэн;
- Цар тахлын өмнөх үеэс аж ахуйн нэгжүүдийн 49% нь ажилтны тоог цөөлсөн бол 43% нь өөрчлөлт оруулаагүй, 8% нь ажилтны тоог нэмсэн. Аж ахуйн нэгжүүдийн 58%-д нь шаардагдах мэргэжлийн ажиллагсад дутагдалтай байгаа ба мэргэжлийн ажиллах хүчний хомсдол нь бизнест сөрөг нөлөөтэй байдаг гэжээ. Гадаад худалдаа, аялал жуулчлал, хүнсний боловсруулах үйлдвэрлэл, тээврийн салбарт мэргэжлийн ажиллах хүч илүү ихээр дутагдаж байна. Аж ахуйн нэгжүүдийн 68% нь цалингийн зардлыг ямар нэг хэмжээгээр өсгөсөн байна;
- Аж ахуйн нэгжүүдийн 83%-д нь ханган нийлүүлэлтийн сүлжээнд тасалдал гарч, холбогдох зардал дунджаар 43.7%-аар өсөж, бараа материал хүлээн авдаг хугацаа энгийн үеэс дунджаар 17 ба түүнээс дээш хугацаагаар хоцорч зарим тохиолдолд хэзээ хүлээн авах нь тодорхойгүй болсон байна. Ханган нийлүүлэлт тасалдаж байгаа нь түүхий эд, бараа үйлчилгээний үнэ өсөх (66%), түүхий эд материал олж авахад хүндрэлтэй болсон (45%), бараа үйлчилгээг цаг хугацаандаа хэрэглэгчдэд хүргэж чадахгүй болсон (30%) зэргээр бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж байна;
- Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 58% нь гадаад төлбөр тооцоо гүйцэтгэхэд төлбөр тооцоо саатах, төлбөр тооцоо хийх гадаад валютын олдоц муу зэргээр хүндрэл үүсэж байна;
- Аж ахуйн нэгжүүдийн 48%-ийн үйл ажиллагаанд ОХУ-Украины нөхцөл байдал нөлөөлсөн ба бараа материал түүхий эдийн олдоц муудсан, тээвэр логистик саатсан зэрэг хүндрэлүүд үүсгэж байна.

**Бизнес эрхлэгчдийн зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

- Бизнес эрхлэгчид үнийн өсөлтийн бизнес дэх сөрөг нөлөөг бууруулж, үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор үйл ажиллагааны зардлаа хэмнэх, эргэлтийн хөрөнгө, зардлын бүтцэд шинжилгээ хийх, хэрэглэгч үйлчлүүлэгчээ авч үлдэх зорилгоор хямдрал урамшуулал олгох, ажлын байраа цомхотгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна;
- Ханган нийлүүлэлтийн тасалдлын үед чухал шаардлагатай хангамжийг нийлүүлэхийн тулд илүү уян хатан, шуурхай шийдвэрлэх, өөр ханган нийлүүлэгчидтэй сэлгэн ажиллах, дотоод ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгон ажиллаж байна;
- Шаардлагатай ажиллагсдаа авч үлдэхийн тулд шинэ бодлого, стратеги хэрэгжүүлэх, оффист болон зайнаас хослон ажиллах горимыг нэвтрүүлсэн байна. Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 85% нь шаардлагатай ажиллагсдаа өөрсдөө сургаж ажиллаж байна.

**Шаардагдах Төрийн дэмжлэг:**

- Бизнесийн үйл ажиллагаа бүрэн сэргэхэд хил, боомтын асуудлууд шийдэх, тээвэр логистикийн асуудлууд шийдэх, хөнгөлөлттэй зээл, санхүүжилт олгох;
- Харин бизнес дэх үнийн өсөлтийн нөлөөг бууруулах чиглэлд түр хугацааны татварын хөнгөлөлт дэмжлэг (70%), бага хүүтэй урт хугацаатай зээл олгох (69%), түүхий эд хил гаалиар нэвтрүүлэхэд шуурхай нэвтрүүлэх;
- Ажлын байрыг нэмэгдүүлж, шаардагдах мэргэжлийн ажиллах хүчийг нэмж ажиллуулахад мэргэжлийн ажиллах хүчээ хадгалж буй ажил олгогчид санхүү, татварын дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн ажиллах хүчээ сургаж мэргэшүүлэхэд санхүү, татварын дэмжлэг үзүүлэх, төрөөс нэгдсэн үр дүнтэй арга хэмжээ, стратеги төлөвлөгөө батлах;
- Ханган нийлүүлэлт тасалдаж, хоцорч байгаа сөрөг нөлөөллийг бууруулахад хилийн боомтын үйл ажиллагааг хэвийн болгох (73%), түүхий эдийн экспорт/импорт хийхэд хил, гаалиар шуурхай горимоор нэвтрүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжсэн бодлого шийдвэр гаргах зэрэг нь чухал дэмжлэг болно гэжээ.



## II-1. Бизнесийн нөхцөл байдал

2022 оны 9 сарын байдлаар бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа тогтвортой, хэвийн болсон эсэх, бизнесийн үйл ажиллагааг сэргээж, хэвийн явуулахад ямар хүндрэл байгаа тухай судалгааны үр дүнг энэ хэсэгт нэгтгэн дүгнэв.


### Бизнесийн үйл ажиллагааны нөхцөл байдал

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 79% нь үйл ажиллагаа тогтвортой ажиллаж байгаа бол 21% нь үйл ажиллагаа хэвийн, тогтвортой ажиллаж чадахгүй байна. Үйл ажиллагаа нь тогтвортой, хэвийн байж чадахгүй байгаа аж ахуйн нэгжүүдээс тулгарч буй хамгийн гол хүндрэлийг тодруулахад 55% нь бараа материал, түүхий эдийн үнэ өссөн, 45% нь үйл ажиллагаатай холбогдох зардлын өсөлт, 39% нь иргэдийн худалдан авах чадвар муудсан, 34% нь тээвэр логистикийн хүндрэл зэргийг нэрлэсэн.

Цар тахлын өмнөх үетэй харьцуулахад судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 86%-ийн үйл ажиллагаа нь ямар нэг түвшинд сэргээд байна. Аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагааны дундаж сэргэлт 47.5 орчим хувьтай ба бизнес эрхлэгчид бүрэн хүчин чадлынхаа дунджаар 47.5%-ийг ашиглан ажиллаж байна.

Тодруулбал аж ахуйн нэгжүүдийн 17%-д нь дөнгөж бага зэрэг сэргэлт ажиглагдаж байгаа ба ойролцоогоор 30 хүртэл хувиар үйл ажиллагаа сэргэсэн гэж хариулсан. Харин 59% нь бизнесийн үйл ажиллагаа 31-80% хувиар сэргээд байгаа бол 9% нь бизнесийн үйл ажиллагаа бүрэн сэргэсэн гэжээ. Түүнчлэн бизнесүүдийн 11% нь хүндрэлээс сэргэж чадаагүй байгаа бол, 3% нь үйл ажиллагаагаа зогсоосон байна. (Зураг II-1-1)

Зураг II-1-1. Бизнес эрхлэгчдийн цар тахлын хүндрэлээс эргэн сэргэсэн байдал



Бизнесийн үйл ажиллагааны сэргэлтийн түвшнийг үйл ажиллагааны салбараар авч үзвэл тээвэр, гадаад дотоод худалдаа, уул уурхай, аялал жуулчлал, барилгын салбарт “сэргэж чадаагүй” аж ахуйн нэгжийн тоо илүү олон байна. Харин эрчим хүчний салбарын бизнес эрхлэгчид бүгд үйл ажиллагаа нь тодорхой хэмжээнд сэргэн үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн хүнсний боловсруулах үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарт үйл ажиллагааны сэргэлт нь бусад салбаруудтай харьцуулахад илүү сайн байна. (Зураг II-1-2)

Зураг II-1-2. Бизнес сэргэлтийн түвшин, салбараар



Бизнесийн үйл ажиллагаа бүрэн сэргэхэд хамгийн гол нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулахад бизнес эрхлэгчдийн 38% нь хилийн боомтын асуудлууд шийдэгдэх, 26% нь тээвэр логистикийн асуудлууд шийдэх, мөн 26% нь хөнгөлөлттэй зээл, санхүүжилт, хэрэглэгч үйлчлүүлэгчийн эрэлт сэргэх зэргийг нэрлэсэн. (Зураг II-1-3)

Зураг II-1-3. Бизнес бүрэн сэргэхэд нөлөөлж буй хүчин зүйлс



Бизнесийн үйл ажиллагаа сэргэж хэвийн явуулахад нөлөөлж буй хүчин зүйлсийг бизнесийн салбараар авч үзвэл уул уурхай, тээврийн салбарт хилийн боомтын асуудлууд шийдэгдэх, эрчим хүч, гадаад худалдааны салбарт тээвэр логистикийн асуудал шийдэгдэх, хөдөө аж ахуйн салбарт хөнгөлөлттэй зээл санхүүжилт, мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарт хэрэглэгчийн эрэлт зэрэг хүчин зүйл чухал нөлөөтэй байна гэжээ. (Зураг II-1-4)


Зураг II-1-4. Бизнес бүрэн сэргэхэд нөлөөлж буй хүчин зүйлс, салбараар



**Бизнес дэх нөлөө**

Бизнес эрхлэгчдээс цар тахал бизнесийн аль хэсэгт хамгийн их нөлөөтэй байгааг тодруулахад 61% нь борлуулалт, 48% үйл ажиллагааны тасралтгүй байдал, 47% нь бараа бүтээгдэхүүн, нөөц хөрөнгөд хамгийн их нөлөөтэй байна гэжээ. (Зураг II-1-5)

Зураг II-1-5. Цар тахлын бизнест хамгийн гол нөлөөлсөн хүчин зүйлс



Цар тахал бизнесийн аль хэсэгт хамгийн их нөлөөлж байгааг салбараар авч үзвэл бүх салбарт борлуулалт хамгийн гол нөлөөлөгч хүчин зүйл байсан ба барилга, уул уурхайн салбарт бараа бүтээгдэхүүн, нөөц хөрөнгөд, мэдээлэл технологи, харилцаа холбооны салбарт ажиллах хүчинд, тээвэр аялал жуулчлалын салбарт үйл ажиллагааны тасралтгүй байдалд нөлөөтэй байна. (Зураг II-1-6)


Зураг II-1-6. Цар тахлын бизнест хамгийн гол нөлөөлсөн хүчин зүйлс, салбараар



ОХУ-ын олон улс дахь нөхцөл байдал нь Монгол улсын бизнес эрхлэгчдэд хэрхэн нөлөөлж байгааг тодруулахад судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 48% нь ОХУ, Украины нөхцөл байдал бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлсөн ба бараа материал түүхий эдийн олдоц муудсан, тээвэр логистик саатсан зэрэг гол нөлөөтэй байна. (Зураг II-1-7)

Бизнесийн салбараар нь ангилан авч үзвэл эрчим хүч, гадаад худалдаа, тээврийн салбарт илүү нөлөөтэй байна.

Зураг II-1-7. Бизнест ОХУ-Украины нөхцөл байдал нөлөөлсөн байдал



### Нэгдүгээр хэсгийн дүгнэлт

- 2022 оны 9 сарын байдлаар судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 79% нь үйл ажиллагаа тогтвортой ажиллаж байгаа бол 21% нь үйл ажиллагаа хэвийн, тогтвортой ажиллаж чадахгүй байна. Үйл ажиллагаа хэвийн тогтвортой явуулахад бараа материал, түүхий эдийн үнийн өсөлт, үйл ажиллагаатай холбогдох зардлын өсөлт, иргэдийн худалдан авах чадвар муудсан, тээвэр логистикийн хүндрэл зэрэг сөргөөр нөлөөлж байна.
- Цар тахлын өмнөх үетэй харьцуулахад судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 86% нь үйл ажиллагаанд нь ямар нэг түвшинд сэргэсэн ба ахуйн нэгжүүд дунджаар хүчин чадлынхаа 47.5% орчим хувийг ашиглан ажиллаж байна. Тээвэр, гадаад дотоод худалдаа, уул уурхай, аялал жуулчлал, барилгын салбарт “сэргэж чадаагүй” аж ахуйн нэгжийн тоо илүү олон байна.
- Бизнесийн үйл ажиллагаа бүрэн сэргэхэд хил, боомтын асуудлууд шийдэгдэх (38%), тээвэр логистикийн асуудлууд шийдэх (26%), хөнгөлөлттэй зээл, санхүүжилт (26%), хэрэглэгч үйлчлүүлэгчийн эрэлт сэргэх (26%) зэрэг нь гол нөлөөтэй байна. Бизнесийн салбараар авч үзвэл уул уурхай, тээврийн салбарт хилийн боомтын асуудлууд шийдэгдэх, эрчим хүч, гадаад худалдааны салбарт тээвэр логистикийн асуудал шийдэгдэх, хөдөө аж ахуйн салбарт хөнгөлөлттэй зээл санхүүжилт, мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарт хэрэглэгчийн эрэлт зэрэг хүчин зүйл чухал нөлөөтэй байна.
- Цар тахал бизнесийн байгууллагын борлуулалт (61%), үйл ажиллагааны тасралтгүй байдал (48%), бараа бүтээгдэхүүн, нөөц хөрөнгөд (47%) хамгийн ихээр нөлөөлсөн. Салбараар авч үзвэл бүх салбарт борлуулалт хамгийн гол нөлөөлөгч хүчин зүйл байсан ба барилга, уул уурхайн салбарт бараа бүтээгдэхүүн, нөөц хөрөнгөд, мэдээлэл технологи, харилцаа холбооны салбарт ажиллах хүчинд, тээвэр аялал жуулчлалын салбарт үйл ажиллагааны тасралтгүй байдалд гол нөлөөтэй байна.
- Аж ахуйн нэгжүүдийн 48%-ийн үйл ажиллагаанд ОХУ, Украины нөхцөл байдал нөлөөлсөн ба бизнесийн үйл ажиллагаанд бараа материал түүхий эдийн олдоц муудсан, тээвэр логистик саатсан зэрэг гол нөлөөтэй байна. Эрчим хүч, гадаад худалдаа, тээврийн салбарт илүү нөлөөлж байна.

## II-2. Бизнес дэх үнийн өсөлт, санхүүгийн нөлөө

Үнийн өсөлт бизнес эрхлэгчдэд хэрхэн нөлөөлж байгаа, бизнес эрхлэгчдийн зүгээс үүсээд буй нөхцөл байдалд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа, үнийн өсөлтийн нөлөөллийг бууруулахад бизнест ямар дэмжлэг хэрэгтэй байгаа тухай судалгааны үр дүнг энэ хэсэгт нэгтгэсэн болно.

### Бизнес дэх үнийн өсөлтийн нөлөө

Үнийн өсөлтийн дарамт бизнест ирж байгаа тухайд судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 96% нь бизнест үнийн өсөлтийн дарамт ирж байна, тодруулбал 62% нь үнийн өсөлтийн дарамт үргэлж байна гэсэн бол 34% нь заримдаа л үнийн өсөлтийн дарамт мэдрэгдэж байна гэжээ.

Зураг II-2-1. Бизнест үнийн өсөлтийн дарамт ирж байгаа давтамж, салбараар



Үнийн өсөлт бүх салбарын аж ахуйн нэгжүүдэд дарамт болж байгаа ба хамгийн ихээр **уул уурхай, эрчим хүч, хүнсний бус боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалын** салбаруудад нөлөөлж байна. (Зураг II-2-1)

Зураг II-2-2. Бизнест үнийн өсөлтийн дарамт мэдрэгдэж буй хугацаа



Үнийн өсөлтийн дарамт бизнест ямар хугацаанд мэдрэгдэж байгаа тухайд 43% нь сүүлийн хагас жилийн хугацаанд, 57% нь сүүлийн жилд 6 сараас дээш хугацаанд мэдрэгдэж байна гэжээ. (Зураг II-2-2)

Зураг II-2-3. Бизнест үнийн өсөлтийн дарамт хамгийн ихээр нөлөөлж буй хэсгүүд



Үнийн өсөлт бизнесийн аль хэсэгт илүү нөлөөтэй байгааг тодруулахад 70% нь түүхий эд, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өссөн, 65% нь үйл ажиллагааны зардал өссөн, 54% нь цалин нэмэгдүүлэх шаардлагатай болсон тул ажиллах хүчтэй холбоотой зардал өссөн, 50% нь борлуулалтын хэмжээ буурсан зэргээр бизнест нөлөөлж байна. (Зураг II-2-3)


Үнийн өсөлт бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг бизнесийн салбаруудаар авч үзвэл худалдааны салбарт бараа материалын үнэ өссөн, үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагааны зардал өссөн, хөдөө аж ахуйн салбарт татварын өр төлбөрт орсон зэргээр нөлөөлж байна. (Зураг II-2-4)

Зураг II-2-4. Бизнест үнийн өсөлтийн дарамт хамгийн ихээр нөлөөлж буй хэсгүүд, салбараар



Үнийн өсөлт бизнесийн ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг тодруулахад бизнес эрхлэгчдийн дөнгөж 4% нь ашигт өөрчлөлт ороогүй байгаа бол 96% нь ашигт ажиллагаанд ямар нэг сөрөг нөлөөтэй байсан гэжээ. **Үнийн өсөлтийн нөлөөгөөр бизнесийн ашиг дунджаар 52%-аар буурсан байна.** Тодруулбал 25% нь ашиггүй ажиллаж байгаа бол 54% нь ашгийн түвшин 50 хүртэл хувиар буурсан, 15% нь ашиг нь 50-аас дээш хувиар буурсан байна. (Зураг II-2-5)

Зураг II-2-5. Үнийн өсөлтийн бизнесийн ашигт нөлөөлсөн хувь



Бизнес эрхлэгчдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шаардагдах дэмжлэг

Үнийн өсөлттэй үед бизнес эрхлэгчдийн зүгээс үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгааг тодруулахад 81% нь үйл ажиллагааны зардлаа хэмнэж эхэлсэн бол 77% нь эргэлтийн хөрөнгө, зардлын бүтцэд дахин анализ хийсэн, 63% нь хэрэглэгч үйлчлүүлэгчээ авч үлдэх зорилгоор хямдрал, урамшуулал олгосон байна. Харин судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 57% нь ажлын байраа цомхотгосон гэжээ. (Зураг II-2-6)

Зураг II-2-6. Үнийн өсөлтийн үед бизнес эрхлэгчдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ



Бизнес эрхлэгчид үйл ажиллагаатай холбогдох ямар төрлийн зардлаа хамгийн эхэнд танаж байгаа тухайд 58% нь хөрөнгө оруулалтын зардлаа бууруулж, худалдан авалтаа хойшлуулж байгаа бол 42% нь ажиллах хүчтэй холбогдох зардлаа танасан, 38% нь түрээсийн зардлаа бууруулж, оффис болон үйл ажиллагаа явуулдаг талбайн хэмжээг багасгаж байна. (Зураг II-2-7)

Зураг II-2-7. Үнийн өсөлтөөс шалтгаалан хамгийн эхэнд бууруулж буй зардлын төрлүүд



Цаашид бизнес дэх үнийн өсөлтийн нөлөөг бууруулах чиглэлд ямар дэмжлэг хэрэгтэй байгаа тухайд судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 70% нь түр хугацааны татварын хөнгөлөлт дэмжлэг, 69% нь бага хүүтэй урт хугацаатай зээл олгох, түүхий эд хил гаалиар нэвтрүүлэхэд шуурхай хөнгөлөлттэй, ногоон сувгаар нэвтрүүлэх зэргийг онцолсон байна. (Зураг II-2-8)

Зураг II-2-8. Бизнес дэх үнийн өсөлтийн сөрөг нөлөөг бууруулахад шаардлагатай дэмжлэг



Бизнес дэх үнийн өсөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлд авч хэрэгжүүлэх дэмжлэг арга хэмжээг салбаруудаар авч үзвэл бүх салбарууд түр хугацааны татварын хөнгөлөлт,



дэмжлэг хэрэгтэй байна гэсэн. Мөн хөдөө аж ахуй, үйлчилгээ, барилга, худалдаа, аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчид бага хүүтэй, урт хугацаатай зээл, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт түүхий эд, бараа материалыг хил гаалийн хөнгөвчилсөн ногоон сувгаар нэвтрүүлэх нь чухал гэжээ. (Зураг II-2-9)

Зураг II-2-9. Бизнес дэх үнийн өсөлтийн сөрөг нөлөөг бууруулахад шаардлагатай дэмжлэг




Үнийн өсөлт өндөр байгаа энэ үед судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 52% нь цаашид бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй явуулж чадна гэж үзэж байна, мөн бизнес эрхлэгчдийн 48% нь 2022 оны сүүлээр үнийн өсөлт буурахгүй гэж таамаглаж байгаа бол, 47% нь тодорхой хэлж мэдэхгүй байна гэжээ.

**Санхүү, зээл**

Бизнес эрхлэгчдийн 71% нь мөнгөн гүйлгээгээ сайжруулах зорилгоор зээл авах хүсэлтэй байгаа ба зээл авахаар аль нэг банк санхүүгийн байгууллагад хандсан байна. Зээл авах хүсэлтэй байгаа аж ахуйн нэгжүүдийн давхардсан тоогоор 49% нь арилжааны банканд, 22% нь хөнгөлөлттэй зээл олгох төсөл, хөтөлбөрт, 12% нь банк бус санхүүгийн байгууллагад, 10% нь ломбард, хувь хүнтэй холбогдсон байна. (Зураг II-2-10)

Зээл авах хүсэлт гаргасан бизнес эрхлэгчдийн дөнгөж 27% нь зээлээ авч чадсан бол 73% нь зээлээ авч чадаагүй байна. Мөн бизнес эрхлэгчдийн 66% нь зээлийн олдоц муу байна гэсэн бол 16% нь шаардлага хангасан тохиолдолд зээл олдож байна гэжээ.

Зураг II-2-10. Зээл авах хүсэлт илгээсэн, холбогдсон байгууллагууд




Зээл авахад ямар бэрхшээл, хүндрэл байгаа тухайд 75% нь хүүгийн түвшин өндөр, 59% нь барьцаа хөрөнгийн шаардлага хангаж чадахгүй байх, 50% нь хугацаа хангалттай урт биш зэргийг нэрлэсэн байна. (Зураг II-2-11)

Зураг II-2-11. Зээл авахад тулгарч буй бэрхшээл



Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 58% нь гадаад төлбөр тооцоо гүйцэтгэхэд ямар нэг хүндрэл үүсэж байна гэсэн. Тодруулбал 30% нь гадаад төлбөр тооцоо саатаж байгаа бол 28% нь төлбөр тооцоо хийх гадаад валютын олдоц муу байна гэжээ. (Зураг II-2-12)

Зураг II-2-12. Гадаад төлбөр тооцоо хийхтэй холбоотой хүндрэл байгаа эсэх



### Хоёрдугаар хэсгийн дүгнэлт

- Үнийн өсөлтийн дарамт бизнес эрхлэгчдийн 96%-д нь тогтмол болон заримдаа давтамжтай мэдрэгдэж байгаа бөгөөд хамгийн ихээр уул уурхай, эрчим хүч, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбаруудад нөлөөлж байна.
- Бизнесийн үйл ажиллагаанд түүхий эд, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өссөн (70%), үйл ажиллагааны зардал өссөн (65%), цалин ажиллах хүчтэй холбоотой зардал өссөн (54%), борлуулалтын хэмжээ буурсан (50%) зэргээр үнийн өсөлт нөлөөлжээ.
- Үнийн өсөлтийн дарамт бизнес эрхлэгчдийн 43%-д нь сүүлийн хагас жилийн хугацаанд, 57%-д нь 6 сараас дээш хугацаанд мэдрэгдэж байна. Үнийн өсөлтийн нөлөөгөөр бизнесийн ашиг дунджаар 52%-аар буурсан ба нийт судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 96%-ийх нь ашигт ажиллагаа буурсан байна.
- Бизнес эрхлэгчдийн зүгээс үнийн өсөлтийн бизнес дэх сөрөг нөлөөг бууруулж, үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор үйл ажиллагааны зардлаа хэмнэж эхэлсэн (81%), эргэлтийн хөрөнгө, зардлын бүтцэд шинжилгээ хийсэн (77%) , хэрэглэгч үйлчлүүлэгчээ авч үлдэх зорилгоор хямдрал, урамшуулал олгосон (63%), ажлын байраа цомхотгосон (57%) байна.
- Цаашид Төрөөс бизнес дэх үнийн өсөлтийн нөлөөг бууруулах чиглэлд түр хугацааны татварын хөнгөлөлт дэмжлэг (70%), бага хүүтэй урт хугацаатай зээл олгох (69%), түүхий эд хил гаалиар нэвтрүүлэхэд шуурхай нэвтрүүлэх дэмжлэгүүд хэрэгтэй гэжээ.
- Үнийн өсөлт өндөр байгаа энэ үед бизнес эрхлэгчдийн 52% нь цаашид бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй явуулна гэсэн эерэг хүлээлттэй байна. Мөн бизнес эрхлэгчдийн 48% нь 2022 оны сүүлээр үнийн өсөлт буурахгүй гэж таамаглаж байгаа бол, 47% нь тодорхой хэлж мэдэхгүй байна.
- Бизнес эрхлэгчдийн 71% нь мөнгөн гүйлгээгээ сайжруулах зорилгоор зээл авахаар аль нэг банк санхүүгийн байгууллага, хувь хүнд хандсан бөгөөд дөнгөж 27% нь зээлээ авч чадсан. Зээл авахад ямар хүндрэл байгаа тухайд хүүгийн түвшин өндөр (75%), барьцаа хөрөнгийн шаардлага хангаж чадахгүй (59%), хугацаа хангалттай урт биш (50%) зэргийг нэрлэсэн.
- Бизнес эрхлэгчдийн 66% нь зээлийн олдоц муу байна гэсэн бол 16% нь шаардлага хангасан тохиолдолд зээл олдож байна гэжээ.
- Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 58% нь гадаад төлбөр тооцоо гүйцэтгэхэд гадаад төлбөр тооцоо саатах (30%), төлбөр тооцоо хийх гадаад валютын олдоц муу (28%) зэргээр хүндрэл үүсэж байна гэсэн байна.


### II-3. Бизнес дэх ажиллах хүчний нөлөө, өөрчлөлт

Цар тахал үргэлжилж, бизнес, эдийн засаг сэргэж буй энэ үед аж ахуйн нэгжүүд ажиллагсдын тоондоо өөрчлөлт оруулсан эсэх шаардлагатай мэргэжлийн ажиллах хүчний олноо, ажиллах хүчээ хадгалж үлдэхийн тулд бизнес эрхлэгчдийн зүгээс ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа цаашид ямар дэмжлэг хэрэгтэй байгаа тухайд энэ хэсэгт тодрууллаа.

#### Бизнес дэх нөлөө


Цар тахлын өмнөх үетэй харьцуулахад аж ахуйн нэгжүүд ажиллагсдын тоонд ямар өөрчлөлт оруулаад байгаа тухайд судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 49% нь ажилтны тоог цөөлсөн бол 43% нь өөрчлөлт оруулаагүй, 8% нь ажилтны тоог нэмсэн байна. (Зураг II-3-1)

Зураг II-3-1. Цар тахлын өмнөх үетэй харьцуулахад ажиллагсдын тооны өөрчлөлт



Бизнес эрхлэгчдээс шаардагдах мэргэжлийн ажиллагсад байгаа эсэхийг тодруулахад 58% нь хангалттай байхгүй, 36% нь хангалттай байна гэсэн. Мэргэжлийн ажиллах хүч бизнесийн аль салбарт илүү дутагдаж байгааг тодруулах зорилгоор салбараар нарийвчлан авч үзвэл гадаад худалдаа, аялал жуулчлал, хүнсний боловсруулах үйлдвэрлэл, тээврийн салбарт мэргэжлийн ажиллах хүч илүү ихээр дутагдаж байна. (Зураг II-3-2)

Зураг II-3-2. Шаардагдах мэргэжлийн ажиллах хүч байгаа эсэх, салбараар



Мөн мэргэжлийн ажиллах хүчний хомсдол нь бизнест сөрөг нөлөөтэй байдаг гэж бизнес эрхлэгчдийн 67% нь үзсэн. Ажиллах хүчний хомсдол нь бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг тодруулахад бизнес эрхлэгчдийн 60% нь шаардлага хангасан ажиллагсдыг авч үлдэхийн тулд цалинг нэмэгдүүлдэг, 50% нь үйлдвэрлэл үйл ажиллагааны хэмжээгээ бууруулах шаардлагатай болдог, 47% нь санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг хангалттай олон байлгаж чадахгүй байх зэргээр нөлөөлж байна. (Зураг II-3-3)

Зураг II-3-3. Бизнес дэх ажиллах хүчний хомсдолын нөлөө



Ажиллах хүчний хомсдолын нөлөөг аж ахуйн нэгжийн хэмжээгээр нарийвчлан харвал бичил, жижиг аж ахуйн нэгжүүд шаардлагатай ажиллах хүч дутагдахад үйлдвэрлэл, үйл ажиллагааны хэмжээгээ бууруулдаг бол дунд, том аж ахуйн нэгжүүд шаардлагатай ажиллагсдын цалингийн хэмжээг нэмэгдүүлдэг байна. (Зураг II-3-4)

Зураг II-3-4. Ажиллах хүчний хомсдолын нөлөө, аж ахуйн нэгжийн хэмжээгээр




Бизнес эрхлэгчдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шаардагдах дэмжлэг

Шаардлагатай ажиллагсдаа авч үлдэхийн тулд бизнес эрхлэгчдийн 58% нь шинэ бодлого, стратеги хэрэгжүүлж байгаа бол 39% нь оффист болон зайнаас ажиллах хосолсон ажиллах горимыг нэвтрүүлэн ажиллаж байна. Түүнчлэн судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 85% нь шаардлагатай ажиллагсдаа өөрсдөө сургаж байна.

Цар тахал үргэлжилж, бизнес, эдийн засаг сэргэж байгаа энэ үед бизнес эрхлэгчдийн цалингийн зардал дунджаар хэрхэн өөрчлөгдөж байгаа тухайд тодруулахад 21% нь цалингийн зардалд өөрчлөлт ороогүй, 11% нь цалингийн зардлаа буруулж ажлын байраа цомхотгосон гэсэн бол 68% нь цалингийн зардлыг ямар нэг хэмжээгээр өсгөсөн гэжээ. (Зураг II-3-5)

Зураг II-3-5. Цалингийн зардлын дундаж өөрчлөлт



Цаашид ажлын байрыг нэмэгдүүлж, шаардагдах мэргэжлийн ажиллах хүчийг олж ажиллуулахад бизнест төрөөс ямар дэмжлэг хэрэгтэй тухайд 69% нь мэргэжлийн ажиллах хүчээ хадгалж буй ажил олгогчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, 60% нь мэргэжлийн ажиллах хүчээ сургаж мэргэшүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, 56% нь төрөөс нэгдсэн үр дүнтэй арга хэмжээ, стратеги төлөвлөгөө батлах хэрэгжүүлэх, 36% нь эдийн засаг дахь боломжуудын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дижитал дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх гэжээ. (Зураг II-3-6)

Зураг II-3-6. Бизнест шаардагдах мэргэжлийн ажиллах хүчийг олж ажиллуулах, ажлын байр нэмэгдүүлэхэд шаардагдах дэмжлэг



Бичил, жижиг аж ахуйн нэгжүүдэд ажлын байраа хадгалахад санхүүгийн дэмжлэг чухал байгаа бол дунд аж ахуйн нэгжүүдэд ажиллагсдаа сургаж, мэргэшүүлэхэд санхүү, татварын дэмжлэг хэрэгтэй байна. (Зураг II-3-7)

Зураг II-3-7. Бизнест шаардагдах мэргэжлийн ажиллах хүчийг олж ажиллуулах, ажлын байр нэмэгдүүлэхэд шаардагдах дэмжлэг, аж ахуй нэгжийн орлогын түвшинээр



### Гуравдугаар хэсгийн дүгнэлт

---

- Цар тахлын өмнөх үетэй харьцуулахад аж ахуйн нэгжүүдийн 49% нь ажилтны тоог цөөлсөн бол 43% нь өөрчлөлт оруулаагүй, 8% нь ажилтны тоог нэмсэн байна.
- Аж ахуйн нэгжүүдийн 58% нь одоогоор шаардагдах мэргэжлийн ажиллагсад хангалттай байхгүй, 36% нь хангалттай байгаа ба мэргэжлийн ажиллах хүчний хомсдол нь бизнест сөрөг нөлөөтэй (67%) байдаг гэжээ. Гадаад худалдаа, аялал жуулчлал, хүнсний боловсруулах үйлдвэрлэл, тээврийн салбарт мэргэжлийн ажиллах хүч илүү ихээр дутагдаж байна.
- Ажиллах хүчний хомсдол нь шаардлага хангасан ажиллагсдыг авч үлдэхийн тулд цалингийн зардал нэмэгдүүлэх (60%), үйлдвэрлэл үйл ажиллагааны хэмжээг бууруулах (50%), бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг хангалттай олон байлгаж чадахгүй байх (47%) зэргээр бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж байна.
- Аж ахуйн нэгжүүдийн 21% нь цалингийн зардалд өөрчлөлт ороогүй, 11% нь цалингийн зардлаа бууруулж ажлын байраа цомхотгосон гэсэн бол 68% нь цалингийн зардлыг ямар нэг хэмжээгээр өсгөсөн гэжээ.
- Бизнес эрхлэгчдийн зүгээс шаардлагатай ажиллагсдаа авч үлдэхийн тулд шинэ бодлого, стратеги хэрэгжүүлж байгаа (58%), оффист болон зайнаас ажиллах хосолсон ажиллах горимыг нэвтрүүлэн (39%) ажиллаж байна. Мөн судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 85% нь шаардлагатай ажиллагсдаа өөрсдөө сургаж байна.
- Цаашид ажлын байрыг нэмэгдүүлж, шаардагдах мэргэжлийн ажиллах хүчийг олж ажиллуулахад бизнест Төрөөс хэрхэн дэмжих тухайд мэргэжлийн ажиллах хүчээ хадгалж буй ажил олгогчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх (69%), мэргэжлийн ажиллах хүчээ сургаж мэргэшүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх (60%), төрөөс нэгдсэн үр дүнтэй арга хэмжээ, стратеги төлөвлөгөө батлах (56%) зэргийг нэрлэжээ.


## II-4. Бизнес дэх ханган нийлүүлэлтийн сүлжээний нөлөө, өөрчлөлт

Цар тахал, гадаад зах зээлийн таагүй нөхцөл байдал аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчдийн бараа материалын ханган нийлүүлэлтийн сүлжээнд хэрхэн нөлөөлж байгаа, ханган нийлүүлэлтийг тасралтгүй явуулахын тулд бизнесүүд ямар арга хэмжээ авч үйл ажиллагаа нь хэрхэн өөрчлөгдөж байгаа тухайд энэ хэсэгт тодрууллаа.

### Бизнес дэх нөлөө


Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 83% нь ханган нийлүүлэлтийн сүлжээ тасарсан гэж хариулсан ба бизнест хэрхэн нөлөөлж байгааг тодруулахад 49% нь маш ихээр нөлөөлсөн бол 42% нь зарим талаар нөлөөлсөн, 9% нь нөлөөлөөгүй, үйл ажиллагаа явуулахад хамааралгүй гэжээ. Ханган нийлүүлэлтийн сүлжээний тасалдал бизнесийн аль салбарт илүү нөлөөтэй байгааг нарийвчлан авч үзвэл барилга (98%), боловсруулах үйлдвэрлэл (97%), гадаад дотоод худалдаа (96%), эрчим хүч (92%)-ний салбарын бизнес эрхлэгчдэд хамгийн их нөлөөлтэй байна. (Зураг II-4-1)

Зураг II-4-1. Ханган нийлүүлэлтийн сүлжээний тасалдлын бизнес дэх нөлөө, салбараар



Ханган нийлүүлэлтийн сүлжээний тасалдлыг ханган нийлүүлэгч түнш орноор авч үзвэл БНХАУ, Зүүн өмнөд азиас ханган нийлүүлэлт авдаг бизнесүүдэд илүү их тасалдсан байна. (Зураг II-4-2)


Зураг II-4-2. Танай бизнест ханган нийлүүлэлтийн сүлжээ тасалдсан уу?



Бизнес эрхлэгчдийн зүгээс ханган нийлүүлэлт тасалдаж байгаа үндсэн шалтгааныг тодруулахад давхардсан тоогоор 63% нь хилийн боомтын хязгаарлалт, 47% нь тээвэр логистикийн тасалдал, 38% нь цар тахлын хязгаарлалтын арга хэмжээ, түүхий эдийн үнийн өсөлт зэргийг нэрлэсэн байна. (Зураг II-4-3)



Зураг II-4-3. Ханган нийлүүлэлт тасалдаж байгаа үндсэн шалтгаан



Ханган нийлүүлэлт тасалдаж байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг тодруулахад 66% нь түүхий эд, бараа үйлчилгээний үнэ өссөн, 45% нь түүхий эд материал олж авахад хүндрэлтэй болсон, 30% нь бараа үйлчилгээг цаг хугацаандаа хэрэглэгчдэд хүргэж чадахгүй болсон зэрэг хүндрэлийг голлон нэрлэжээ. (Зураг II-4-4)


Зураг II-4-4. Бизнес тасалдсан ханган нийлүүлэлт тасалдсан нь хэрхэн нөлөөлж байгаа тухайд



Дотоод, ОХУ, БНХАУ улсуудтай ханган нийлүүлэлтийн түнштэй бизнес эрхлэгчдийн хувьд түүхий эд материал олж авахад хүндрэл үүсэж байгаа бол Европын холбоо, Зүүн өмнөд азийн түнштэй бизнес эрхлэгчид бараа үйлчилгээг цаг хугацаандаа хүргэж чадахгүй байх нь илүү нөлөөтэй байна.


Судалгаанд оролцон бизнес эрхлэгчдээс хамгийн гол ханган нийлүүлэгч нь аль улс оронд байдаг тухайд 37% нь дотоод, 39% нь БНХАУ, 17% нь ОХУ, 3% нь Европын холбоо, 2% нь зүүн өмнөд ази, 1% нь бусад улс орнууд байна. (Зураг II-4-5)

Зураг II-4-5. Ханган нийлүүлэлтийн түнш орнууд



Ханган нийлүүлэлтийн тасалдлаас шалтгаалан судалгаанд оролцсон аж ахуй нэгжийн зардал хэрхэн өөрчлөгдсөн тухайд бизнес эрхлэгчдийн 6% нь ямар нэг өөрчлөлтгүй, 92% нь зардал өссөн гэсэн. Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн зардал дунджаар 43.7%-аар өссөн байна. (Зураг II-4-6)


Зураг II-4-6. Ханган нийлүүлэлтийн тасалдлаас шалтгаалан зардлын өөрчлөлт



Ханган нийлүүлэлтийн тасалдлаас шалтгаалан бараа, материал хүлээн авдаг хугацаанд ямар өөрчлөлт орсон тухайд бизнес эрхлэгчдийн **71% нь хугацаа хоцорч байгаа, 20% нь хэзээ хүлээн авахаа хэлж мэдэхгүй, тодорхойгүй** болсон гэжээ.

Бизнес эрхлэгчдийн бараа материалаа хүлээн авч байгаа дундаж хугацааг тооцож үзвэл 39% нь хэвийн үеэс 17 хоногоор хоцорч байгаа бол 32% нь нэг сараас дээш хугацаагаар хоцорч бараа материал, түүхий эдээ хүлээн авч байна. (Зураг II-4-7)


Зураг II-4-7. Ханган нийлүүлэлтийн тасалдлаас шалтгаалан бараа материал хүлээн авах хугацааны өөрчлөлт



Бизнес эрхлэгчдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шаардагдах дэмжлэг


Ханган нийлүүлэлт тасалдаж байгаа үед бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах зорилгоор ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа тухайд давхардсан тоогоор 62% нь чухал шаардлагатай хангамжийг нийлүүлэхийн тулд илүү уян хатан, шуурхай шийдвэрлэх, өөр ханган нийлүүлэгчидтэй сэлгэн ажиллаж байгаа бол 52% нь дотоод ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгон ажиллаж байна. (Зураг II-4-8)

Зураг II-4-8. Ханган нийлүүлэлтийн тасалдлыг бизнесүүд хэрхэн шийдвэрлэж байгаа тухайд



Бизнес дэх ханган нийлүүлэлтийн тасалдлын сөрөг нөлөөллийг бууруулахын тулд бизнес эрхлэгчид хэрхэн шийдвэрлэж байгаа тухайд түнш орнуудаар ангилан авч үзвэл бүх бизнес эрхлэгчид ханган нийлүүлэлтийг шуурхай шийдвэрлэх, өөр ханган нийлүүлэгчидтэй хамтрах эсвэл сэлгэн ажиллахад илүү анхаарч асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Дотоод, ОХУ, БНХАУ-ын түнштэй бизнес эрхлэгчид дотоодоос зарим бараа материалын нийлүүлэлтийн сүлжээ бий болгож байгаа бол Европын холбооны түншүүдтэй бизнесүүд ажилчдаа өөр ажил үүрэгт сургаж байна. Түүнчлэн дотоод, БНХАУ, Зүүн өмнөд азийн түнштэй бизнесүүд илүү шинэ технологид хөрөнгөн оруулалт хийж байна. (Зураг II-4-9)

Зураг II-4-9. Бизнесүүд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түнш орнуудаар



Бизнесийн үйл ажиллагаа дахь ханган нийлүүлэлт тасалдаж, хоцорч байгаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд Төрөөс авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодруулахад 73% нь хилийн боомтын үйл ажиллагааг хэвийн болгох, 48% нь түүхий эдийн экспорт/импорт хийхэд хил, гаалиар хөнгөлөлттэй горимоор нэвтрүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжсэн бодлого шийдвэр гаргах зэргийг онцолсон байна. (Зураг II-4-10)

Зураг II-4-10. Бизнес дэх ханган нийлүүлэлтийн тасалдлын сөрөг нөлөөг бууруулах чиглэлд авч хэрэгжүүлж болох дэмжлэг, арга хэмжээ



Дөрөвдүгээр хэсгийн дүгнэлт

- Аж ахуйн нэгжүүдийн 83%-д нь ханган нийлүүлэлтийн сүлжээнд тасалдал гарч байна. БНХАУ, Зүүн өмнөд азиас ханган нийлүүлэлт авдаг бизнесүүдэд илүү их тасалдал үүссэн байна. Хилийн боомтын хязгаарлалт (63%), тээвэр логистикийн тасалдал (47%), цар тахлын хязгаарлалтын арга хэмжээ, түүхий эдийн үнийн өсөлт зэрэг хүчний зүйлс голлон нөлөөлж байна. Барилга, боловсруулах үйлдвэрлэл, гадаад дотоод худалдаа, эрчим хүчний салбарын бизнест хамгийн их нөлөөтэй байна.
- Ханган нийлүүлэлт тасалдаж байгаа нь түүхий эд, бараа үйлчилгээний үнэ өссөн (66%), түүхий эд материал олж авахад хүндрэлтэй болсон (45%), бараа үйлчилгээг цаг хугацаандаа хэрэглэгчдэд хүргэж чадахгүй болсон (30%) зэргээр бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж байна.
- Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн хамгийн гол ханган нийлүүлэгчээр дотоод (37%), БНХАУ (39%), ОХУ (17%), Европын холбоо (3%), бусад (3%) улс орнууд байдаг байна.
- Ханган нийлүүлэлтийн тасалдлаас шалтгаалан аж ахуйн нэгжүүдийн зардал дунджаар 43.7%-аар өсөж, аж ахуйн нэгжүүдийн 91%-ийх нь бараа материал хүлээн авдаг хугацаа энгийн үеэс 17 ба түүнээс дээш хугацаагаар хоцорч зарим тохиолдолд хэзээ хүлээн авах нь тодорхойгүй болсон байна.
- Ханган нийлүүлэлт тасалдаж байгаа үед бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах зорилгоор чухал шаардлагатай хангамжийг нийлүүлэхийн тулд илүү уян хатан, шуурхай шийдвэрлэх, өөр ханган нийлүүлэгчидтэй сэлгэн ажиллах (62%), дотоод ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгон (52%) ажиллаж байна.
- Бизнесийн үйл ажиллагаа дахь ханган нийлүүлэлт тасалдаж, хоцорч байгаа сөрөг нөлөөллийг бууруулахад Төрөөс авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодруулахад 73% нь хилийн боомтын үйл ажиллагааг хэвийн болгох, 48% нь түүхий эдийн экспорт/импорт хийхэд хил, гаалиар шуурхай горимоор нэвтрүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжсэн бодлого шийдвэр гаргах зэргийг онцолсон байна.

## II-5. Судалгаанд оролцогчдын мэдээлэл


Судалгааг Улаанбаатар хот, орон нутгийн бизнес эрхлэгчдийн дунд цахим хэлбэрээр 2022 оны 8 сарын 25-ний өдрөөс 9 сарын 4-ний өдрүүдэд явуулсан бөгөөд МҮХАҮТ-ын гишүүн болон гишүүн бус 1073 аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг хамруулав.

Нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаа явуулж буй байршлаар нь ангилан харвал 49.7% нь Улаанбаатар, 50.3% нь орон нутагт байна. Салбараар нь авч үзвэл 20% нь үйлчилгээ, 32% нь дотоод худалдаа, 15% гадаад худалдаа, 11% нь хүнсний бус үйлдвэр, 9% нь хүнсний үйлдвэр байна. Ажиллагсдын тоогоор нь авч үзвэл 46.2% нь 10 хүртэлх ажилтантай, 29.4% нь 11-50 хүртэлх ажилтантай, 9.1% нь 51-200 хүртэлх ажилтантай, 5.1% нь 200-аас дээш ажилтантай байгаа бол 10.2% нь хувиараа бизнес эрхлэгч байна. Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 55.9% нь 300 саяас доош орлоготой бизнес эрхлэгчид, 17.8% нь 301 сая - 1 тэрбум төгрөгийн орлоготой, 26.3% нь нэг тэрбумаас дээш орлоготой аж ахуйн нэгжүүд байна.


Зураг II-5-1. Судалгаанд оролцсон байгууллага, салбараар



Зураг II-5-2. Жилийн борлуулалтын орлого



Зураг II-5-3. Ажиллагсдын тоо



## НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Монгол улсын эдийн засгийн өсөлт 2020 онд 4.4 хувиар агшиж, 2021 онд 1.4 хувиар өссөн дүнтэй гарсан. 2022 оны II улирлын байдлаар өмнөх мөн үетэй харьцуулахад 1.9 хувиар тэлсэн ба энэхүү өсөлтийг хөдөө аж ахуй, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт голлон бүрдүүлсэн бөгөөд харин уул уурхайн салбар агшиж, барилгын салбарын уналт хоёр дахь жилдээ үргэлжилж байна. Энэ 9 сард Азийн хөгжлийн банкнаас Монгол улсын 2022 оны эдийн засгийн өсөлтийн таамаглалыг 2.2 хувиас 1.7 хувьд хүргэн бууруулсан бөгөөд ОУВС-ийн судлаачид энэ оны өсөлтийн таамаглалыг 1% хувь гэж үзсэн.

МҮХАҮТ-аас явуулсан судалгааны дүнгээс харахад 2022 оны 9 сарын байдлаар судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 86%-ийн үйл ажиллагаа нь ямар нэг түвшинд сэргэсэн хэдий ч бизнесийн байгууллагууд дунджаар хүчин чадлын 47.5% орчим хувийг ашиглаж байгаа гэсэн нь эдийн засгийн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

2022 оны 8 сарын байдлаар улсын төсвийн тэнцэл 899.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ба үүнд цар тахлын үед татвар, нийгмийн даатгалын шимтгэл, халамжийн чиглэлээр төсвийн шинжтэй арга хэмжээг хэрэгжүүлсэн нь нөлөөлжээ. 2022 оны эхний хагас жилд төлбөрийн тэнцэл 1.1 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан. Харин гадаад худалдааны тэнцэл 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 534.8 сая ам.доллороор өссөн боловч уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ бууралттай байна. Монгол улсын экспортын гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, импортын барааны дотоод эрэлт нэмэгдэж байгаа нь 2021 оны эцэст 4.3 тэрбум ам.доллартой тэнцэж байсан гадаад валютын нөөцийг бууруулахад хүргэж, 2022 оны 8 сарын байдлаар 2.7 тэрбум ам доллар болж буурав.

БНХАУ-ын “Тэг-КОВИД” бодлогоос шалтгаалсан хилийн боомтын хязгаарлалт, тээвэр логистикийн саатлаас нүүрсний болон бусад бүтээгдэхүүний экспорт саатаж, импортын барааны бөөгнөрөл үүсэж, импортын бараа хилээр орж ирэх хугацаа уртассан төдийгүй үнэ өссөн байна. Судалгаагаар аж ахуйн нэгжүүдийн 83%-д нь ханган нийлүүлэлтийн сүлжээнд тасалдал гарч, холбогдох зардал дунджаар 43.7%-аар өсөж, бараа материал хүлээн авдаг хугацаа энгийн үеэс дунджаар 17 хоног ба түүнээс дээш хугацаагаар хоцорч зарим тохиолдолд хэзээ хүлээн авах нь тодорхойгүй болсон гэсэн хариултыг өгсөн байна.

Замын-үүд боомтын саатлаас шалтгаалж хүнсний бүтээгдэхүүний импортын үнэ өсөж, гадаад зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлтөөр дотоод дах шатахууны үнийн өсөлт хурдсаж, инфляцын түвшин 2021 оны эцэст 13.4 хувь, 2022 оны 8 сард 14.4 хувь байна. Судалгаанаас үнийн өсөлтийн дарамт бизнес эрхлэгчдийн 43%-д нь сүүлийн хагас жилийн хугацаанд, 57%-д нь хагас жилээс дээш хугацаанд мэдрэгдэж, бизнесийн ашиг дунджаар 52%-аар буурсан үр дүн гарсан.

ОХУ-д тавьсан олон улсын санхүүгийн хоригоос шалтгаалж импортын барааны төлбөр хугацаанаас хоцрох, гадаад валютын илүүдэл эрэлт үүсэж, арилжааны банкаар худалдаалагдаж буй валютын хэмжээнд хязгаарлалт тавьсан, 2023 онд төлөгдөх гадаад өр, бондын төлбөрийн дарамт зэрэг нь гадаад валютын нөөцийн дутагдлыг үүсгэж, төгрөгийн ханшийг сулруулж, импортын барааны үнэд нөлөөлж байна. Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 58%-д гадаад төлбөр тооцоо гүйцэтгэхэд төлбөр тооцоо саатах, төлбөр тооцоо хийх гадаад валютын олдоц муу зэргээр хүндрэл үүсэж байна. Мөн тэдгээрийн 48%-ийн үйл ажиллагаанд ОХУ-Украины дайны нөхцөл нөлөөлж бараа материал түүхий эдийн олдоц муудсан, тээвэр логистик саатсан зэрэг хүндрэлүүд тулгарчээ.

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилттэй холбоотойгоор зээл олголт нэмэгдэж, 2020 оны эцэст 17.2 их наяд төгрөг байсан зээлийн хэмжээ 2022 оны I улиралд 23.5 их наяд төгрөгт хүрч 5 улирал дараалан өссөн. Харин 2022 оны II улиралд банкуудын шинээр олгох зээлийн өсөлт удааширч, нийт зээлийн үлдэгдэл буурчээ. Энэ хугацаанд хөдөө аж ахуй, худалдааны салбарт шинээр олгосон зээлийн хэмжээ өсөж, уул уурхай, боловсруулах, үл хөдлөх, барилгын салбарт шинээр зээл олголт буурсан байна. Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 71% нь зээл авахаар аль нэг банк

санхүүгийн байгууллага, хувь хүнд хандсан бөгөөд дөнгөж 27% нь зээлээ авч чадсан ба бизнес эрхлэгчдийн 66% нь зээлийн олдоц муу байна гэж хариулсан.

Эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн статистик тоон мэдээлэл болон бизнес эрхлэгчдийн дунд явуулсан судалгааны дүнгээс үзэхэд цар тахлын дараах эдийн засаг бизнесийн нөхцөл байдал тааруу, бизнес эрхлэгчдийн хувьд хилийн боомтын болон тээвэр логистикийн хүндрэлүүд, мэргэжлийн ажиллах хүчний хомсдол, санхүүгийн эх үүсвэр дутагдалтай, гадаад төлбөр тооцооны хязгаарлалт гэсэн хатуу сорилтуудтай удаан хугацаанд тулгарч байна. Ийм үед Монголбанкнаас инфляцыг зорилтот түвшинд тогтоон барих зорилгоор бодлогын хүүг 12 хувь хүртэл нэмж, мөнгөний нийлүүлэлтийг бууруулах шийдвэр гаргасан нь бизнесийн зээлийн олдоц улам бүр багасаж, цаашид бизнесийн үйл ажиллагааны сэргэлтийг хязгаарлах, эдийн засгийг хумих нөлөө үзүүлэхээр байна.



## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Цар тахлын дараах бизнесийн орчинд тулгамдаж байгаа хилийн боомт, тээвэр логистик, ханган нийлүүлэлтийн сүлжээ, гадаад төлбөр тооцоо, валютын нөөц болон инфляцтай холбоотой олон асуудлууд байгаагаас харахад эдийн засаг, бизнесийн таагүй хүнд нөхцөл байдал үргэлжлэх төлөвтэй байна.

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа сэргээж хэвийн явуулахад хилийн боомтын ба тээвэр логистикийн асуудлуудыг шийдэх, хөнгөлөлттэй зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, татварын дэмжлэг үзүүлэх явдал нэн тэргүүнд шаардлагатай гэж үзсэн. Мэргэжлийн ажиллах хүчнийг сургах, тэднийг хадгалах болон ажлын байрыг нэмэгдүүлэхэд Засгийн газраас бодлогоор дэмжлэг үзүүлэх хэрэгтэйг онцолсон ба Монгол улсын эдийн засгийг сэргээхэд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах нь нэн чухал гэсэн байна.

Эдийн засаг бизнесийг сэргээхэд засгийн газраас хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдэд тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэх, тэдэнд хэрэгтэй дэмжлэгүүдийг үзүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Хилийн боомт, тээвэр логистикийн асуудлыг нэн тэргүүнд тавьж, шийдвэрлэх бодитой ажлуудыг хэрэгжүүлэх
2. Хөрөнгө оруулалтын хуулийн шинэчилсэн найруулгыг яаралтай батлуулах, гадаадын шууд хөрөнгө оруулалт татах нээлттэй бодлогын хүрээнд нэгдсэн цогц арга хэмжээ явуулах
3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг яаралтай батлах, төр хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих
4. Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар авах явдлыг нэмэгдүүлэх замаар тэдгээрийг дэмжих
5. Экспортыг дэмжих чиглэлээр экспортын санхүүжилт болон экспортын даатгалын тогтолцоог бүрдүүлэх
6. Татвар ба нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт, хойшлуулалтын дэмжлэг үзүүлэх, түүнчлэн НӨАТ-ыг бүгд жигд (5%) төлдөг байх тогтолцоог бүрдүүлэх
7. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд банкны системийг дэмжих, бизнесийн зээлийн үүсвэрийг нэмэгдүүлэх
8. Гадаад төлбөр тооцоог хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх
9. Аж ахуйн нэгжүүд дотоодын хөрөнгийн зах зээлээс бага хүүгээр санхүүжих боломжийг нэмэгдүүлэх
10. Төсвийн бодлого төлөвлөлт нь дунд урт хугацааны үр дагавартайг анхаарч, макро эдийн засгийн сөрөг үр дагавар бага байх зөв бүтэц агуулгатай төсөвтэй болох, төсвийн алдагдлыг бууруулах чиглэлээр дорвитой алхам хийх
11. Ажил эрхлэлтийн идэвхийг буурахад гол нөлөөлж байгаа хавтгайруулсан халамжийн бодлогыг хумьж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлого гаргаж, хэрэгжүүлэх
12. Ажлын байрыг хамгаалахад чиглэсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, мэргэжлийн ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлэх ба мэргэшүүлэх талаар аж ахуйн нэгжүүдийг дэмжин урамшуулах

Сүүлийн хоёр жилийн хугацаанд Засгийн газар ба бизнес эрхлэгчид хоёулаа урьд өмнө тулгарч байгаагүй олон сорилтууд дунд ажилласан. Өнөөдрийн хүнд нөхцөл байдал болон цаашид учирч болох эрсдэлүүдийг аль болох хохирол багатай даван туулахын тулд төр ба хувийн хэвшил асуудлыг хамтдаа хэлэлцэж, илүү уялдаа холбоотой хамтран ажиллах шаардлагатай байгаа бөгөөд үүний тулд нээлттэй, үр дүнтэй уулзалтуудыг тогтмол явуулах, харилцан санал солилцох үр дүнтэй байнгын ажиллагаатай тогтолцоог хөгжүүлж хадгалах нь чухал байна.

Нэг талаас Засгийн газар бизнесийн илүү таатай, тогтвортой орчныг бий болгох, шаардлагатай дэмжлэгүүдийг үзүүлж, нөгөө талаас бизнес, хувийн хэвшил нь ажлын байр, өрсөлдөх давуу тал, инновац, бүтээмжийн өсөлтөөр сэргэлтийг авчрах бөгөөд цаашид эдийн засгийн өсөлтийг хангаж, эдийн засгийг тэлэх бүрэн боломжтой юм.







## **МҮХАҮТ-ын Судалгааны институт**

Монгол Улс, Улаанбаатар хот 17011,  
Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма  
Гандигийн гудамж, МҮХАҮТ-ын байр

**Утас: +976-77277070**  
**Факс: +976-11-324620**

 [research@mongolchamber.mn](mailto:research@mongolchamber.mn)